

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ
ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД
ОЛОН НИЙТЭЭС ИРСЭН САНАЛЫН ТОВЬЁГ**

2021.12.17

№	№	Байгууллагын нэр	Албан бичгийн дугаар, огноо	Санал	Саналыг тусгасан эсэх
1	1	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ	2021.11.17, 159/21	1.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт /3 дугаар зүйл/ Хуулийн төсөлд "зөвлөх үйлчилгээ" гэсэн тодорхойлолтыг хассан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 5.1.15-д заасан үйлчилгээг бүр мөсөн хассан мэт харагдаж байгаа тул уг үйлчилгээ нь шинэчилсэн найруулгын аль нэр томъёонд хамааралтай эсэхийг ойлгомжтой болгох. /3.1.1-"ажил"; 3.1.2-"бараа"; 3.1.16-"үйлчилгээ"/	Зөвлөх үйлчилгээг үйлчилгээнд хамааруулахыг тодорхой болгож хуулийн төсөлд тусгасан.
2		"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ	2021.11.17 № 159/21	2.Техникийн чадавх болон туршлагын шаардлага /16 дугаар зүйл/ Тендерт оролцогч хуулийн төслийн 14.1-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг нотлохын тулд 16.2.3, 16.2.5 дахь ажил гүйцэтгэх боловсон хүчин, хүний нөөц, мэргэжлийн ур чадвар болон машин механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байрны мэдээллийг хуулийн 54 дүгээр зүйлд зааснаар бүртгэлд оруулсан байх, мөн хүний нөөц, машин механизмыг төсөлд давхардуулахгүй гэж заасан нь бодит нөхцөлтэй уялдахгүй байна. Учир нь, 1-рт. Ялангуяа барилга угсралтын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд улирлын чанартай тул хөрөнгө, санхүүгээс шалтгаалан байнга тогтмол ажилтан ажиллуулж цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөх боломж нөхцөл бага учраас тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг гэрээгээр авч ажиллуулдаг. Мөн манай Монголын нөхцөлд нарийн мэргэжлийн инженер техникийн ажилтнуудын нөөц дутмаг байтал инженер техникийн ажилтныг өөр төсөл дээр давхардуулан ажиллуулахгүй гэх нь боломжгүй;	Бүртгэлд хамрагдаагүй тоног төхөөрөмж, инженер техникийн ажилтанг санал болгоход тухай бүр түүнтэй байгуулсан гэрээ, түрээсийн гэрээ нотлох баримтыг одоогийн адилаар тендерт ирүүлэх боломж нээлттэй. Бүртгэлд хамруулж байгаа нь нэг нотлох баримт мэдээллийг

3	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		3. Хуулийн үйлчлэх хүрээ /4 дүгээр зүйл/ Хуулийн төслийн 4.6 дахь хэсгийн дараа 4.7 "Хувьцааны тавь /50/ болон түүнээс дээш хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь төрийн болон орон нутгийн өмчөөр худалдан авалт хийх тендерт оролцох эрхгүй" гэж шинээр нэмэх.	Аливаа этгээдийг тендер ирүүлэхийг эрхийг хязгаарлах боломжгүй. Харин ирүүлсэн тендерийг захиалагчаас хараат гэх нөхцөлөөр ерөнхий шаардлага хангахгүй гэж татгалзахаар заасан.
4	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		4. Худалдан авах ажиллагааны цахим систем /8 дугаар зүйл/ Хуулийн шинэчилсэн найруулгын гол зорилго нь худалдан авах ажиллагааны тогтолцоог илүү ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангах, шийдвэр гаргах ажиллагаа дахь хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс хүний оролцоог бууруулж, худалдан авах ажиллагааны бүх үе шатанд цахим байхаар зохицуулагдах шаардлагатай байна. Тухайлбал, тендерийн баримт бичгийг боловсруулах, хянах, үнэлэх, хэрэгжилтэд хяналт тавих... г.м. Тиймээс дээрх шаардлагуудыг хангах зүйл, заалтуудыг хуулийн төсөлд нэмж тусгах.	Саналын дагуу аль болох тодорхой тусгасан.
5	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		5.Техникийн тодорхойлолт /11 дүгээр зүйл/ 1.Хуулийн төслийн 11.7-д "... эсхүл түүнийг орлох боломжтой бусад бараа...", мөн 11.8-д "... дүйцэхүйц..." гэж заасан нь хуулийн 11.1-ийг зөрчин, чанарын хувьд ижил бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн шударга өрсөлдөх боломжийг хааж, тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлж, угсардаг аж ахуйн нэгжүүдэд илт давуу тал олгодог.	Тодорхой бараа, ажил, үйлчилгээг нэрлэн заасан тохиолдолд түүнийг орлох боломжтой барааг санал болгох эрхийг олох нь өрсөлдөөнийг хамгаалах зэрэг үр дагавартай гэж үздэг тул саналыг хүлээн авах боломжгүй.
6	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		2.Мөн хуулийн төслийн 11.3 дахь хэсэг нь аль нэг оролцогчдод илт давуу эрхийг олгож байгаа тул хасах. Иймээс техникийн тодорхойлолтод үйлдвэрлэгч, барааны тэмдэг, хэлбэр, марк зааж ажлын зураг боловсруулдаг, мөн үйлдвэрлэгч, нийлүүлэгчийг тухайлан заах, "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотголуудыг хасаж, техникийн шаардлага, стандартыг заасан байхаар найруулан өөрчлөх.	Захиалагч тодорхой төрлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх талаар шаардлага тавих эрхтэй. Энэхүү эрхийг хязгаарлах нь төрөөс тодорхой бодлого хэрэгжүүлэх, хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах боломжийг хязгаарлана. Иймд саналыг хүлээн авах боломжгүй.
7	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		3.Хуулийн төслийн 11.9 дэх хэсгийн дараа 11.10 "Ажил, үйлчилгээний үр дүнд бий болох аливаа оюуны өмчийн эрхийг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд эзэмших нөхцөлийг техникийн тодорхойлолтод зааж болно" гэж нэмэх.	Санал авахаар хүргүүлсэн төслийн 10.7 дахь хэсэгт тусгасан тул давхардуулан тусгах шаардлагагүй.

8	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		6.Санхүүгийн чадавхын шаардлага /15 дугаар зүйл/ Хуулийн төслийн 15.2.4, 16.2.1, 16.2.2 дахь хэсэгт "...сүүлийн 5 хүртэл жилийн..." гэснийг "...сүүлийн 2 жилийн..." гэж өөрчлөн, оролцогчдын тоог үл хязгаарлаж, тэгш өрсөлдөх боломж олгох.	Саналын дагуу хугацааг багасгаж 3 хүртэл жил байхаар тусгасан.
9	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		7.Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах /18 дугаар зүйл/ Хуулийн төслийн 18.3 дахь хэсгийг "Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно" гэж найруулах.	Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах эрхийг хоног хугацаагаар хязгаарлах нь хэт явцуурсан болно. Иймд ажлын 5 хоногийн дотор нэмэлт, өөрчлөлт оруулсан бол хугацааг зохих ёсоор сунгах тухай санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 20.3 дахь хэсэгт заасан.
10	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		8. Өрсөлдөөнт хэлэлцээний арга /37 дугаар зүйл/ Хуулийн төслийн уг зүйл, заалт 37.1.1, 37.1.2 дахь заалт нь худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шударга, үнэн зөв зохион байгуулах зарчмыг алдагдуулах тул хасах саналтай байна. Учир нь төсөлд худалдан авах ажиллагаа /тендер/ зохион байгуулах хугацааг 2 дахин богиносгосон. Гэрээ шууд байгуулах аргыг боловсронгуй болгох гэдэгт дээрх зүйл, заалт багтаж байгаа эсэхийг тодорхой болгох.	Гэрээ шууд байгуулахаар хуульд заасан зохицуулалтыг багасгаж өрсөлдөөн нэмэгдүүлэх, аж ахуй эрхлэгчийн оролцоог хангах шаардлагаар уг тендер шалгаруулалтын аргыг шинээр тусгасан тул саналыг хүлээн авах боломжгүй.
11	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		9.Тендерийн болон гүйцэтгэлийн баталгаа Хуулийн төслийн 43 дугаар зүйл "Гүйцэтгэлийн баталгаа", 44 дүгээр зүйл "Урьдчилгаа төлбөрийн баталгаа" нь гүйцэтгэгчдийн хувьд санхүүгийн том дарамт болдог тул тендерт ялсан тохиолдолд тендерийн баталгааг шууд гүйцэтгэлийн баталгаа болгож шилжүүлдэг болгон өөрчлөх. Ингэснээр олон компанийн хувьд тэгш, ил тод өрсөлдөх боломж илүү нээгдэж, санхүүгийн хувьд гүйцэтгэгчид дэмжлэг болох юм.	Тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгааны нөхцөл, зориулалт, хугацаа нь ялгаатай тул тендерийн баталгааг шууд гүйцэтгэлийн баталгаа болгох боломжгүй. Чөлөөлөгдсөн тендерийн баталгааны эх үүсвэрийг гүйцэтгэлийн баталгаанд шилжүүлэх эрх нь оролцогчид нээлттэй болно. Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 44.3 дахь хэсэгт гүйцэтгэлийн баталгааны дүнг урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд оруулан тооцох зохицуулалт тусгагдсан.

12	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		10. Захиалагчийн шийдвэрт гомдол гаргах /60 дугаар зүйл/ Хуулийн төслийн 60.14.3 дэх заалтын дараа: "-60.14.4 гомдол гаргагчийн гомдол үндэслэлтэй бол гомдол гаргагчтай гэрээ байгуулахыг даалгах; -60.14.5 захиалагч болон үнэлгээний хорооны хууль бус үйл ажиллагааны улмаас тендерт оролцогчдод учруулсан хохирлыг гаргуулах шийдвэр гаргах: -60.14.6 захиалагч болон үнэлгээний хорооны шийдвэр хууль бус эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоох" гэж нэмэх	Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар зөвлөлийн гаргах шийдвэр нь гэрээ байгуулахыг даалгах, хохирол нөхөн төлүүлэхээр шийдвэрлэх нь шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудал тул саналыг тусгах боломжгүй.
13	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		11. Захиалагч, үнэлгээний хороо, гишүүд, оролцогчдыг хариуцлагажуулах талын зүйл, заалтыг тодорхой тусгах.	Саналын дагуу үнэлгээний хорооны гишүүд болон захиалагч хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг нэмэгдүүлсэн.
14	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		Төслийн найруулгатай холбоотой санал: 1. 1.1 Энэ хуулийн зорилго нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд ил тод, шударга ёс. өрсөлдөх тэгш боломжийг хангах, захиалагч, гүйцэтгэгч тэгш эрх, үүрэгтэй, хариуцлагатай байх, гэрээний чөлөөт байдлын зарчмыг баримтлах , үр ашигтай, олон нийтийн итгэлийг хангасан байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.	Гэрээний харилцааг хуулийн төслийн холбогдох хэсэгт зохицуулах тул зорилгод оруулах шаардлагагүй.
15	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		2. 5.1.2 Монгол Улсын хуулийн дагуу өмнөх жилийн татварын эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй, эсхүл өр төлбөр төлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа;	Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 5.1.2-т хугацаа хэтэрсэн өртэй эсэхийг оролцогчийн ерөнхий нөхцөлийг шалгахад харгалзан үзэхээр тусгасан. Түүнчлэн шалгарсан тохиолдолд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хэмжээний өрийг нөхөн төлөх боломжийг олгохоор хуулийн төслийн тендер хянан үзэх хэсэгт заасан.

16	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		3. 5.1.5 Захиалагч болон үнэлгээний хороо, түүний гишүүд нь оролцогч, түншлэлийн гишүүнтэй өрсөлдөөний тухай хуулийн 4.6.1-д заасан харилцан хамааралтай, эсхүл үгсэн хуйвалдсан гэж үзэх бодит үндэслэл байгаа;	Өрсөлдөөний тухай хуульд заасан харилцан хамаарлыг тогтоох нь оролцогчид өөр хоорондоо хамааралгүй, үгсэн хуйвалдаагүй байх агуулгыг илэрхийлж байна. Захиалагч, түүнийг төлөөлж буй нийтийн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1 дэх хэсэгт зааснаар хамааралтай бол ерөнхий шаардлага хангахгүй болохыг
17	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		4. 6.4 Тендерт гадаадын хуулийн этгээд шалгарсан тохиолдолд Монгол Улсад хуулийн этгээд байгуулсны үндсэн дээр үүрэг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно.	Гадаадын этгээдээс бүрдсэн түншлэл шалгарсан байх тохиолдолд Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг оролцуулан гэрээ байгуулна.
18	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		5. 10.1 Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, гэрээний маягт болон холбогдох бусад хууль, журам, аргачлалын дагуу боловсруулна. Гэрээний маягт нь гэрээний чөлөөт байдлын зарчимд үндэслэж гэрээ байгуулагч талуудын санал өгөх эрхийг хязгаарлахгүй байна.	Гэрээний маягыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, улс орон даяар нэг мөр мөрдүүлэх ба оролцогч түүнээс зөрүүтэй саналаа тендер тусгаж ирүүлнэ. Ийнхүү зөрүүтэй саналыг шаардлага хангасан гэж үзсэн бол гэрээнд тусгах ба бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах нь тендер шалгаруулалт явуулсан үр дүнг үгүй хийх, бусад оролцогчдод шударга бус үр дагавар үзүүлнэ.
19	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		6. 11.3 дахь хэсэг 11.5-тай зөрчилдөж байна. Аж ахуйн нэгжүүдийн шударга өрсөлдөх боломжийг хааж, тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлж, угсардаг аж ахуйн нэгжүүдэд илт давуу тал олгож байна.	Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 11.3 дахь хэсэг нь тухайн бараа, ажил, үйлчилгээний үйлдвэрлэлийн процесс, хөдөлмөрийн нөхцөл, хог хаягдлын менежмент зэргийг харгалзан үзэх талаар зохицуулсан тул 11.5 дахь хэсэгт зааснаас өөр ойлголт болно.
20	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		7. 14.6 Захиалагч шаардсан тохиолдолд оролцогч хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан тендерийн гэрээний талаарх мэдээллийг ирүүлнэ.	Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шалгуураар хязгаарлагдах тул тусгайлан заах шаардлагагүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

21	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		8. 15.2.4. сүүлийн 2 хүртэл жилийн хугацаанд оролцогчийн тухайн бараа, ажил, үйлчилгээнд болон салбарт хэрэгжүүлсэн борлуулалтын орлогын мэдээлэл Хэт урт хугацаа тавьсан нь өрсөлдөөнийг хязгаарлаж байна.	Саналын дагуу хугацааг багасгаж 3 хүртэл жил байхаар тусгасан.
22	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		9. 18.3 Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас ажлын 5-с доошгүй хоногийн өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.	Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах эрхийг хоног хугацаагаар хязгаарлах нь хэт явцуурсан болно.
23	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		10. 21.3 Оролцогч өөрийн тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтээ бичгээр болон цахимаар Захиалагчид хүргүүлэх ба ийнхүү сунгаагүй нь түүний тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болохгүй.	Хуулийн төсөлд цахим системээр харилцсан харилцааг бичгээр харилцсан гэж үзэхээр заасан тул цахим шуудангаар харилцах хэлбэрийг бичгээр харилцсан гэж үзэх эрх зүйн боломж одоогоор байхгүй тул тусгах боломжгүй.
24	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		11. 24.3 Тендер шалгаруулалтын гомдол шийдвэрлэх зөвлөлөөс энэ хуулийн 60.12-д заасны дагуу гомдлыг хянах шийдвэр гаргасантай холбоотойгоор захиалагч энэ хуулийн 24.1-д заасан хугацааг ажлын 15 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно. Гомдлыг хянах шийдвэр гаргах буюу гомдлыг хянах ажиллагааг эхлүүлэх шийдвэр гаргах гэж ойлгож болно. Мөн тендерийн хүчинтэй хугацааг арай урт хугацаагаар сунгаснаар гомдол гаргасан болон тендерт оролцогч бусад талуудад Зөвлөлийн шийдвэртэй холбоотой аливаа үйлдэл хийх хугацаа, боломжийг олгох юм.	Саналыг хүлээн авч, холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан
25	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		12. 27.3.3 захиалагчаас тогтоосон эсхүл холбогдох гэрээний нөхцөлөөр тодорхойлсон Иргэний хуульд нийцсэн талуудын эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн байх;	Гэрээний нөхцөлийг захиалагч тодорхойлж, тендер шалгаруулалтын баримт бичигт тусгадаг тул саналыг хүлээн авах боломжгүй.
26	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		13. 28.2 Оролцогч энэ хуулийн 28.1-д заасан тайлбар авах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор холбогдох тайлбарыг захиалагчид хүргүүлнэ.	Тендер шалгаруулалтын арга тус бүрд хариу авах шаардлагатай хугацаа өөр шаардлагатай тул хуульд тусгайлан ижил хоног заах боломжгүй байна.
27	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		14. 27.8-ыг хасах Тендерийн шаардлагад нийцсэн хэд хэдэн тендерт оролцогч байж болохыг үгүйсгэж байна. Хуулийн төслийн 29.1, 10.4-д зааснаар шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх шалгуурыг хангасан байх тул энэ заалтыг хасах	Нэгэнт шаардлагад нийцээгүй татгалзах тул тодорхой хэвээр үлдээх нь зүйтэй байна.

28	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		15. 30.5 нь 31.3-тай уялдахгүй байна.	Саналын дагуу техник алдааг залруулав.
29	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		16. 43.6 Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дунгийн 1-5 хувийг уг хугацаа дуустал саатуулан барих нөхцөлийг захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.	Саналыг тусгалаа.
30	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		17. 50.3 Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд 53.2-т зааснаар мэдээллийн санд бүртгэлтэй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах эрх хязгаарлаагүй 3-аас доошгүй сондгой тооны худалдан авах ажиллагааны болон тухайн тендертэй холбоотой мэргэжлээр мэргэшсэн ажилтныг томилно.	Үнэлгээний хороо нь бие даасан чиг үүрэг хэрэгжүүлдэггүй тул саналыг тусгах боломжгүй байна.
31	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		18. 50.4 Үнэлгээний хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус, тухайн тендерт ашиг сонирхлын зөрчилгүй , хөндлөнгийн гишүүн байна	Хуулийн төсөлд тусгайлан ашиг сонирхлын асуудлыг зохицуулсан тул давхардуулан тусгах шаардлагагүй байна.
32	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		19. 58.1 Захиалагч тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ зөрчсөн болон Үнэлгээний хороо энэ хуулийг зөрчсөн гэж үзвэл тендерийн нээлтээс өмнө сонирхогч этгээд, тендерийн нээлтээс хойш оролцогч тус тус энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болно.	Үнэлгээний хороо нь захилагчийн эрх, үүргийн бие даан хэрэгжүүлдэггүй тул саналыг тусгах боломжгүй байна.
33	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		20. 58.5-ыг Хасах Тендерт оролцогчийн гомдол гаргах эрхийг хязгаарлаж байна.	Саналын дагуу хассан.
34	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		21. 60.14.1 захиалагчийн шийдвэр буюу үйлдлийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөлт оруулах, илт хууль бус болохыг тогтоох;	Саналыг хүлээж авав.
35	"Монголын барилгын инженерүүдийн холбоо" ТББ		22. 60.14.3 зөрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардах, зөрчлийг арилгахыг даалгах.	Утгын хувьд давхардал үүсэхээр байх тул саналыг хүлээн авах боломжгүй.

36	2	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ	2021.10.29, 21/737/АА, 2021.11.24, 21/761/ТЗ	1. Хуулийн төслийн 1.1: Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчөөр санхүүжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжийг ханган төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулахад оршино.	"Хөрөнгөөр худалдан авах" нь санхүүжүүлэх утгыг агуулсан тул саналыг тусгах шаардлагагүй.
37		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		2. 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоос бүрдэнэ. Иргэний, даатгалын болон бусад хууль тогтоомжуудыг нэмэх гэрээ байгуулах, эрх олж авах, гэрээнээс үүдэлтэй маргаан гэх мэт иргэний эрх зүйн харилцаа үүсэх тул Иргэний хууль, мөн урьдчилгаа төлбөрийн болон гүйцэтгэлийн ба чанарын баталгаа, барилга байгууламжийн даатгал гэх мэт шинээр орж ирж байгаа тул даатгалын тухай хуулийг зайлшгүй оруулах.	Худалдан авах ажиллагаанд холбогдох олон хууль тогтоомж байх тул тухайлан нэр заах боломжгүй. Худалдан авах гэрээг Иргэний хуулиар зохицуулах талаар хуулийн төслийн холбогдох хэсэгт тодорхой тусгасан.
38		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		3. 3.1.3. "барилга байгууламжийн ажил" гэж иргэн болон үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг барих, буулгах, өргөтгөх, шинэчлэх, их засвар болон өрөмдлөг, хайгуул хийх зорилгоор хүн хүч, машин техник, тоног төхөөрөмж, материал, технологийг хослуулан ашиглаж гүйцэтгэх ажлыг. "барилга байгууламжийн ажил" гэсэн барилга байгууламжийг барих гээд тодорхойгүй байх тул Барилгын тухай хуулийн 4.1.1-т заасан тайлбарыг оруулах	Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 3.1.1 дэх заалтын "ажил" гэсэн тодорхойлолтод барилга байгууламжийг оруулсан ба Барилгын тухай хуулиар нарийвчлан тодорхойлсон асуудлыг хуулийн төсөлд давхардуулан тусгах шаардлагагүй.

39	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>4. 3.1.5. "гадаадын этгээд" гэж энэхүү хуульд заасан журмын дагуу худалдан авах үйл ажиллагаанд оролцохыг сонирхож байгаа гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд, Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, 25 хувиас илүү гадаадын хөрөнгө оруулалт бүхий Монгол улсад бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг.</p> <p>Ингэж тодотгож өгөхгүй бол гадаадын үйлдвэрлэгч нар Монгол улсад компани байгуулж дотоодын үйлдвэрлэгч, компаниудтай өрсөлдөх боломж бүрдэж байгаа нь хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна.</p>	<p>Монгол Улсад хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, татвар төлж буй хуулийн этгээдийг гадаадын этгээд гэж үзэх нь ялгаварлан гадуурхах шинжтэй тул саналыг тусгах боломжгүй.</p>
40	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>5. 3.1.7. "ерөнхий гэрээ" гэж захиалагчаас байнгын давтамжтай эсхүл тодорхой цаг хугацаанд худалдан авдаг тоо хэмжээ, цаг хугацааны хувьд тодорхойгүй байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг нэг ба түүнээс дээш иргэн, аж ахуй эрхлэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээг. Ерөнхий гэрээний хугацаа заахгүй бол нэг тендерт оролцогчдод монополь давуу эрх үүсэх эрсдэлтэй учир ерөнхий гэрээний хугацааг 3 хүртэлх жил гэж заасныг хэвээр үлдээх.</p>	<p>Саналын дагуу өөрчлөлт оруулсан.</p>
41	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>6. 3.1.10. "нийгэм-эдийн засгийн бодлого" гэж хууль тогтоомжид зааснаар байгаль орчин, нийгэм, эдийн засгийн болон ус, цахилгаан, нөөцийн хэмнэлттэй байх бусад бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах харгалзан үзэх шаардлагатай бодлогыг; "Нийгэм, эдийн засгийн бодлого" гэдгийг маш тодорхой задалж оруулах. Жишээ нь ус, цахилгаан, нөөцийн хэмнэлттэй байх гэх мэт маш тодорхой зааж өгөөгүйгээс энэ заалт хэрэгжихгүй.</p>	<p>Ус, цахилгаан, нөөцийн хэмнэлттэй байх агуулгыг техникийн тодорхойлолтод тусгасан тул саналыг тусгах боломжгүй.</p>

42		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>7. 3.1.11. "оролцогч" гэж захиалагчаас хараат бус, дараах иргэн, төрийн болон орон нутгийн өмчийн биш хуулийн этгээдийг ойлгоно:</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлыг төр, орон нутгийн өмчит хуулийн этгээд өөрөө авч хийх шаардлагагүй. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөж ажлыг нь булаан авч болохгүй. Хуулийн төслийн 46.4-т Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь өөрийн төсвийн хүрээнд захиалагч байхаар.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ямар үйл ажиллагааг эрхлэх чиглэлийг тус хуулиар зохицуулах боломжгүй, бие даасан хуулиар зохицуулдаг тул саналыг тусгах боломжгүй.</p>
43		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>8. 3.1.21. "худалдан авах ажиллагаа" гэж энэ хуульд заасан захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, зураг төсөл сонгон шалгаруулах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах, гэрээний төлбөрийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажиллагааг;</p> <p>Гүйцэтгэгч нь ажлаа хийж дууссан боловч захиалагчаас гэрээний төлбөрөө авч чадахгүй, барьж байгуулсан объектуудаа хүлээлгэн өгч чадахгүй олон жил болдог тул төлбөрийн гүйцэтгэлийг худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хуулийн этгээд хуулиар хариуцах хэрэгтэй.</p>	<p>Худалдан авах гэрээтэй холбоотой хуулийн төслийн хэсэгт уг асуудлыг тусгасан.</p>
44		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>9. 4.6. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд төрийн болон орон нутгийн өмчөөр худалдан авалт хийх тендерт оролцох эрхгүй.</p> <p>Нэмэлт заалт: Нарийвчлан тусгаж өгөхгүй бол зөвхөн 100 хувь төрийн өмчийн хуулийн этгээд оролцох эрхгүй, харин төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд оролцох боломжтой байна.</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулдаг тул саналыг тусгах боломжгүй.</p>

45	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>10. 5.1. Худалдан авах ажиллагаанд шударга ёс ил тод байдлыг хангах, үр ашигтай, захиалагч, гүйцэтгэгч тэгш эрх үүрэгтэй хариуцлагатай байх, гэрээний чөлөөт байдлыг хангах зарчмыг баримтална.</p> <p>Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.</p>	<p>Эдгээр зарчмыг хуулийн төслийн хүрээнд хүрэх зорилт болгож 1 дүгээр зүйлд тодорхойлсон.</p> <p>Хуулийн төсөлд худалдан авах гэрээг хуульд өөрөөр заагаагүй бол Иргэний хуулиар зохицуулахаар тусгасан тул Иргэний хуульд заасан талуудын чөлөөт байдлыг хангах зарчим мөрдөгдөнө.</p>
46	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>11. 6.1.2. Монгол Улсын хуулийн дагуу өмнөх жилийн татварын эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй, эсхүл өр төлбөр төлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа;</p> <p>Өрийн хэмжээг тухайн гүйцэтгэх ажлын төсөвтэй тоогоор эсхүл хувиар тодорхойлж уяж тодорхой болгож өгөхгүй бол зорилтот компаниудад тендерээ өгөхийн бусад компаниас шалтаг хайж татвар, шимтгэлд 100 төгрөгийн өртэй гээд хасдаг тохиолдол их байдаг. Яагаад гэвэл татварын программын нарийвчлалтай холбоотойгоор 100 төгрөгийн үлдэгдэлтэй тодорхойлолт гардаг. Мөн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдүүдэд өр үргэлж үүсэж байдаг тул татварын өртэй байх хугацааг түрүү жилийн эсхүл түрүү улирлын гэж тодотгож өгөх шаардлагатай.</p>	<p>Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 5.1.2-т хугацаа хэтэрсэн өртэй эсэхийг оролцогчийн ерөнхий нөхцөлийг шалгахад харгалзан үзэхээр тусгасан.</p> <p>Түүнчлэн шалгарсан тохиолдолд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хэмжээний өрийг нөхөн төлөх боломжийг олгохоор хуулийн төслийн тендер хянан үзэх хэсэгт заасан.</p>
47	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>12. 6.1.5. Захиалагч болон үнэлгээний хорооны гишүүн нь оролцогч, түншлэлийн гишүүнтэй</p> <p>Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай, эсхүл үгсэн хуйвалдсан гэж үзэх бодит үндэслэл байгаа;</p> <p>Оролцогч түншлэлийн гишүүнтэй харилцан хамаарал бүхий байх боломжтой бөгөөд гагцхүү захиалагч болон үнэлгээний хорооны гишүүнтэй харилцан хамааралгүй байх нь хуулийн үзэл санаанд нийцнэ.</p>	<p>Өрсөлдөөний тухай хуульд заасан харилцан хамаарлыг тогтоох нь оролцогчид өөр хоорондоо хамааралгүй, үгсэн хуйвалдаагүй байх агуулгыг илэрхийлж байна. Захиалагч, түүнийг төлөөлж буй нийтийн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1 дэх хэсэгт зааснаар хамааралтай бол ерөнхий шаардлага хангахгүй болохыг тусгайлан заасан.</p>
48	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>13. 6.1.9 заалтыг хасах</p> <p>Хуулийн төсөлд 6.4-т уг заалтыг тодотгосон заалт байхгүй учир энэ заалтыг хасах, эсхүл хугацааг тодруулах.</p>	<p>Хуулийн төслийн холбогдох зохицуулалтад хугацааг нарийвчлан заасан.</p>

49	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		14. Энэ хуулийн 3.1.11.2-т зааснаар хэд хэдэн этгээд хамтран түншлэл хэлбэрээр тендер ирүүлсэн бол гишүүн тус бүрийн гүйцэтгэх үүргийн хэмжээ тендерийн үнийн 20 хувиас дээш байна. Түншлэл хэлбэрээр гэж тодруулах хэсэг нэмэх	Саналын дагуу өөрчлөлт оруулж, тодорхой болгосон.
50	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		15. 7.3 заалтыг хасах. Туслан гүйцэтгэгч түншлэлийн гишүүн биш учир заавал гэрээ ирүүлэх шаардлагагүй. Туслан гүйцэтгэгч ажиллуулах эсэхээ тендер оролцогч өөрөө шийдэх учир 7.3 гэсэн энэ заалтыг хасах. Хуулийн төслийн 40.2, 40.3-д туслан гүйцэтгэгчийг сольж болохоор заасан байна. Барилгын тухай хуулийн 40.1.18-д туслан гүйцэтгэгчийн ажлын үр дүн, эрсдэлийг захиалагчийн өмнө ерөнхий гүйцэтгэгч хариуцахаар заасан.	Туслан гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой холбогдох тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Иймд тухайн гэрээний дагуу үүрэг гүйцэтгэж байгаа эсэхийг шалгах шаардлагаар анхны гэрээг авах шаардлагатай.
51	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		16. 8.3. Захиалагч 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 10 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцож болно. Бараа, үйлчилгээний зах зээлийг дурын гадаадын иргэн хуулийн этгээд, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдүүдийн бизнес хийх боломжийг хааж, гадаадын этгээдүүдэд боломжийг нээж өгч байгаа заалт гэж үзэж байна.	Саналыг харгалзан үзэж бараа худалдан авах тендер шалгаруулалтынн босго үнийг 1 тэрбум төгрөг байхаар нэмэгдүүлсэн.
52	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		17. 8.6.1. Монгол Улсад бүртгэлтэй, өмчийнх нь 50-аас доошгүй хувь нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хувь хөрөнгөөс бүрдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийт хувьцааны 25 хувиас дээш хувьцааг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байвал гадаадын хөрөнгө оруулалттай болдог ба дээрх заалт нь ойлгомжгүй заалт байна.	Монгол Улсад хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, татвар төлж буй хуулийн этгээдийг гадаадын этгээд гэж үзэх нь ялгаварлан гадуурхах шинжтэй тул саналыг тусгах боломжгүй.

53	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		18. 10.1-д "Гэрээний маягт нь гэрээний чөлөөт байдлын зарчимд үндэслэж талуудын санал өгөх эрхийг хязгаарлахгүй байна." гэж нэмэх. Олон улсын Фидикийн гэрээг загвар болгон хэрэглэх, мөн гэрээнд захиалагчийн шаардлага бус талуудын саналыг чөлөөтэй тусгах боломжтой байх шаардлагатай.	Гэрээний маягтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, улс орон даяар нэг мөр мөрдүүлэх ба оролцогч түүнээс зөрүүтэй саналаа тендерт тусгаж ирүүлнэ. Ийнхүү зөрүүтэй саналыг шаардлага хангасан гэж үзсэн бол гэрээнд тусгах ба бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах нь тендер шалгаруулалт явуулсан үр дүнг үгүй хийх, бусад оролцогчдод шударга бус үр дагавар үзүүлнэ.
54	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		19. 11.3 заалтыг хасах. Мөн хуулийн төслийн 11.3 дахь хэсэг нь аль нэг оролцогчдод илт давуу эрхийг олгож байгаа тул хасах	Захиалагч тодорхой төрлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх талаар шаардлага тавих эрхтэй. Энэхүү эрхийг хязгаарлах нь төрөөс тодорхой бодлого хэрэгжүүлэх, хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах боломжийг хязгаарлана. Иймд саналыг хүлээн авах боломжгүй.
55	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		20. 11.10 заалтыг хасах Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9.5-д "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно" гэж заасан учир 11.10 заалтыг хасах.	Энэ нь захиалагчийн техникийн тодорхойлолт хэрхэн боловсруулах талаар тухайлсан зохицуулалт тул гэрээний үүргийн гүйцэтгэлтэй хамааралгүй.

56	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>21. 13.3.3 энэ хуулийн 13.2-т дүнгээс багагүй нэрлэсэн үнэтэй даатгалын байгууллагын сертификаттай баталгаа</p> <p>Тендерийн, урьдчилгаа төлбөрийн, гүйцэтгэлийн баталгааг банк гүйцэтгэгчийн данснаас хүүгүй авдаг. Харин төсөл хэрэгжүүлж эхлэх үед гүйцэтгэгч байгууллага банкнаас өөрийн хадгалуулсан, барьцаалуулсан мөнгөө өндөр хүүтэй буцааж зээлж төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлдэг.</p> <p>Даатгалын байгууллагаар тендерийн баталгаа гаргуулдаг бол гүйцэтгэгч нар банкинд баталгаа хэлбэрээр их хэмжээний мөнгөө барьцаалуулахгүй. Энэ нь төслийн мөнгө санхүүгийн урсгалыг сайжруулна.</p> <p>Гүйцэтгэлийн баталгаа гэж маш их мөнгийг банк хүүгүй барьцаалж, эргэлдүүлж байдаг. Гэтэл энэ хугацаанд гүйцэтгэгч нар банкнаас өөрсдийн мөнгөө хүүтэйгээр авч дараа дараагийн ажилдаа авч хэрэглэдэг шударга биш механизмыг таслан зогсоох шаардлагатай байна.</p>	<p>Даатгал нь ирээдүйд бий болж болзошгүй эрсдэлийг хариуцах зорилгоор даатгадаг. Харин тендерийн баталгааг улсын орлого болгох нөхцөлүүдийн оролцогчоос үл хамаарах нөхцөл бус, түүний шийдвэрт үндэслэсэн байдаг тул тендерийн баталгааг даатгалын гэрчилгээгээр гаргах нь даатгалын үндсэн зарчимтай нийцэхгүй.</p> <p>Харин гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг даатгалын гэрчилгээний хэлбэрээр ирүүлэх боломжийг хуулийн төсөлд тусгасан.</p>
57	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>22. 13.3.4-т энэ хуулийн 13.2-т дүнгээс багагүй мөнгөн төлбөрийн үүргийг захиалагчийн шаардлагаар гүйцэтгэх үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийн баталгаа</p> <p>үл хөдлөх, хөдлөх хөрөнгө газрыг эргэлтэд оруулж баталгаа гаргах боломжийг нээх шаардлагатай байгаа тул нэмж оруулах</p>	<p>Захиалагч нь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг барьцаалах, баталгаа авах нь практикт хэрэгжих боломжгүйгээс гадна, түүний чиг үүрэгт үл хамаарна. Харин энэ төрлийн үйл ажиллагааг эрхлэх банк, санхүүгийн байгууллага энэхүү хөрөнгийн үндсэн дээр санхүүгийн эх үүсвэр гаргах нь нээлттэй.</p>
58	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>23. 13.8.1. оролцогч тендерийг нээсний дараа, тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө гүйцэтгэгчийн буруутай биш үйл ажиллагаанаас бусад шалтгаанаар тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсан;</p> <p>Зарим тохиолдолд захиалагч тендерт заасан зүйлээс илүү зүйл шаардах, ажил гүйцэтгэх хугацааг өөрчлөх болон бусад олон шалтгаанаар гүйцэтгэгчид хууль бус нэмэлт шаардлага тавьдаг. Ийм тохиолдолд гүйцэтгэгч захиалагчийн саналаас татгалзахаас өөр аргагүй болно. Ийм тохиолдолд баталгааг буцааж өгдөг механизм заавал байх ёстой.</p>	<p>Оролцогч тендер бэлтгэхдээ түүний хүчинтэй байх хугацаа дуусах хүртэл түүнд холбогдох аливаа эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр өөрийн сайн дурын хүсэлт зоригоор санал ирүүлдэг. Энэхүү санал ирүүлэхийг хуулиар шаардаагүй тул ирүүлсэн саналын хүчинтэй хугацаанд бүрэн дагаж мөрдөх нь зайлшгүй үүрэг юм.</p>

59	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>24. 13.8.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх үүргээ биелүүлээгүй, тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариу ирүүлээгүй; "тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу" гэсэн хэсгийг хасах</p>	Тендер шалгаруулалтын баримт бичигт эдгээр бүх процессыг нарийвчлан заасан тул аливаа маргаан үүсэхээс сэргийлэх зорилгоор тендер шалгаруулалтын баримт бичгийг иш татах нь зүйтэй.
60	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>25. 13.12. Энэ хуульд зааснаар тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа, даатгалын сертификат, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн барьцааны эрхийн баталгаа гаргах, улсын орлого болгох журам, Монгол Улсын Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны жагсаалтыг тус тус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална. Гүйцэтгэлийн баталгаанд даатгал болон хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээг оруулж байгаа тул нэмэх</p>	Даатгалын гэрчилгээг гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаанд хэрэглэхийг хуулийн төсөлд заасан тул Засгийн газраас батлах энэхүү журамд хамаарах тул тусгайлан заах шаардлагагүй.
61	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>26. 14.2. Худалдан авах ажиллагаанд цахим системээр дамжуулан лавлах, тодруулах боломжтой болон хууль тогтоомжийн дагуу төрийн эрх бүхий байгууллагаас нийтэд ил тод хөтөлдөг, төрд байдаг мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй. нэмэх</p>	Саналыг хүлээн авч, холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан
62	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>27. 14.3. Гэрээг тусгай зөвшөөрөл эсхүл зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэх шаардлагатай бол захиалагч энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Түншлэлийн тендерт оролцогч тусгай зөвшөөрлийн шаардлагыг дангаар хангах шаардахгүй бөгөөд түншлэлийн аль нэг гишүүн тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байвал тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангасанд тооцно. Энэ агуулгыг оруулж өгөх шаардлагатай. Тэгэхгүй бол нэг нэг компани өөрт шаардлагагүй маш олон тусгай зөвшөөрөл авдаг, түүнийгээ тогтмол ашигладаггүй байдал их байна. Энэ нь хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд дарамт болж байгаа.</p>	Түншлэлийн гишүүн өөрийн гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах шаардлагыг хангасан байхыг хуулийн төсөлд заасан.

63	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		28. 14.6 дахь хэсгийг хасах. Санхүүгийн болон татварын татварын тайлангийн маягт, зааварт энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан техникийн чадавх болон туршлагын талаарх мэдээлэл, нотлох баримтуудыг тусгах боломжгүй.	Оролцогчийн одоо хэрэгжүүлж байгаа болон ирээдүйд хэрэгжүүлэх нь тодорхой болсон гэрээний мэдээлэл нь түүний чадавхыг хянан үзэх зайлшгүй шаардлагатай мэдээлэл байна. Ийм гэрээ байгуулаагүй, гэрээ байгуулах эрх аваагүй этгээд нь энэ тухай мэдэгдсэн нь шаардлага хангасанд тооцохоор тендер хянан үзэх хэсэгт заасан.
64	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		29.Захиалагч нь тухайн барилга байгууламжийн төвөгшлийн ангилал болон зориулалт, хүчин чадлын талаар зураг төсөл боловсруулсан байгууллагын тайлбар, эксперизээр орсон дүгнэлтийг үндэслэж тусгай зөвшөөрөл шаарддаг баймаар байна. Практикт тухайн зарласан ажил нь бага, дунд, өндөр төвөгшилтэй ажил байхад онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн ажлын тусгай зөвшөөрөл шаардах тохиолдол их байна. Тиймээс тухайн зарлагдсан ажилд тохирсон тусгай зөвшөөрлийг шаарддаг байх зохицуулалт оруулж өгмөөр байна.	Хуулиар гэрээг хэрэгжүүлэхэд ач холбогдолгүй шаардлагыг оролцогчдод тавихгүй байхыг тусгайлан заасан тул саналыг тусгах шаардлагагүй байна.
65	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		30. Төвөгшлийн ангиллыг ахиулсан тусгай зөвшөөрөлтэй байхад доод ангиллын ижил тусгай зөвшөөрөлтэй хамтад нь давхардуулж шаардах тохиолдол гарч байна. Жишээ нь БА-3.3, БА-4.3 гэж заасан байна. Иймд энэ талаар зохицуулалт хэрэгтэй байна.	Хуулиар гэрээг хэрэгжүүлэхэд ач холбогдолгүй шаардлагыг оролцогчдод тавихгүй байхыг тусгайлан заасан тул саналыг тусгах шаардлагагүй байна.
66	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		31. Ажиллах хүчний чадавх болон ИТА мэргэжилтэй ажилчдын үндсэн ажилтан байх шалгуур дээр 2022.01.01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр хэд хэдэн газар ажиллах боломжтой заалттай хэрхэн уялдах эсэх. Өөрөөр хэлбэл давхар ажил хийх байгаа хүн нийгмийн даатгал төлөгчийн код /40 код/-оор үндсэн ажилтанд тооцогдох эсэх талаар бусад холбогдох хууль, дүрэм журамтай хэрхэн уялдаж байгаа талаар холбогдох дүрэм журамд оруулж нэг мөр ойлголттой болох саналтай байна.	Захиалагч тухайн ажилтны чиг үүргээс шалтгаалан ялгаатай зохицуулах боломжтой тул хуулийн төсөлд тусгах шаардлагагүй.

67	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		32. 16.2.4 дэх заалтыг хасах. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагддаггүй учир энэ заалтыг хасах	Саналыг харгалзан үзэж байгаль орчин үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний мэдээлэл ирүүлэхээр өөрчилсөн. Төсөвт өртөгт тусгагдсан эсэхээс үл хамааран гүйцэтгэгч сөрөг нөлөөллийг бууруулах талаар аливаа арга хэмжээ авч хэрэгжүүлэх бол тэр тухай мэдээллийг ирүүлэх талаарх мэдээллийг зааж байгаа болно.
68	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		33. 17.3.2. бараа, ажил, үйлчилгээний товч агуулга, тендер зарлах үеийн төсөвт өртөг. Төсөвт өртгийг тендер зарлах үеийн зах зээлийн үнэ, ханшаар бодитой тооцсон байх шаардлагатай.	Төсөвт өртгийг зохион асуудлыг бие даасан хуулиар зохицуулдаг тул тус хуулийн дагуу тооцож, холбогдох эрх бүхий этгээдийн баталсан төсөвт өртөгт үндэслэхээс өөр аргагүй байна.
69	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		34. 23.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацааны дотор хүлээн авсан бүх тендерийн нууцлалыг хадгалж , тендер шалгаруулалтын баримт бичигт заасан газар, товлосон хугацаанд цахим системээр нээнэ. Тендерийг товлосон хугацаанаас өмнө нээхийг хориглоно.	Товлосон хугацаанд цахим системээр тендер нээхээр заасан нь энэ хугацаанаас өөр хугацаанд нээх боломжгүй байхыг илэрхийлнэ. Мөн цахим системийн програмчлалын хувьд мөн товлосон хугацаанаас өмнө болон оролцогчийн нууцалж ирүүлсэн тендерийн хэсгийг нээх боломжгүй.
70	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		35. 24.2. Тендер шалгаруулалтын гомдол шийдвэрлэх зөвлөлөөс энэ хуулийн 60.14-д заасан шийдвэрийг гаргасантай холбоотойгоор захиалагч энэ хуулийн 24.1-д заасан хугацааг ажлын 10 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.	Саналыг хүлээн авсан.
71	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		36. 24.4. Оролцогч өөрийн тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах бол бичгээр эсхүл цахим шуудангаар мэдэгдэх ба ийнхүү сунгаагүй нь түүний тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болохгүй.	Хуулийн төсөлд цахим системээр харилцсан харилцааг бичгээр харилцсан гэж үзэхээр заасан тул цахим шуудангаар харилцах хэлбэрийг бичгээр харилцсан гэж үзэх эрх зүйн боломж одоогоор байхгүй тул тусгах боломжгүй.
72	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		37. 26.4. Энэ хуулийн 26.3-т зааснаар бусад оролцогчид холбогдох баримт, мэдээллийг танилцуулах хугацаа нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш энэ хуулийн 60.1-д зааснаар гомдол гаргах боломжтой хугацаа дуусах хүртэл байна. "Шалгарсан" гэдгийг "бусад" гэж солих	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.

73	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		38. 27.2.4.гэрээний нөхцөлөөр тодорхойлсон талуудын эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулах; Захиалагч гэрээний нөхцөлөө тулган хүлээлгэж давуу эрх эдэлдэг учир "захиалагчаас тогтоосон эсхүл" гэсэн хэсгийг хасах	Гэрээний нөхцөлийг захиалагч тодорхойлж, тендер шалгаруулалтын баримт бичигт тусгадаг тул саналыг хүлээн авах боломжгүй.
74	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		39. 29.2. Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь дараах байна: 29.2.2. ашиглалтын хугацааны зардал; / энэ нь барилга байгууламж барих ажилд хамаарахгүй / 29.2.2.ашиглалтын хугацааны зардал нь барилга байгууламж барих гүйцэтгэгчид хамаарахгүй гэдгийг зааж өгөх.	Ашиглалтын хугацааны зардалтай холбоотой үнэлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлах тул хуульд тусгах шаардлагагүй.
75	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		40. 29.2 хэсэгт буй тайлбарыг тусад нь хуулийн заалт болгож оруулан оноог хэрхэн өгч, дүгнэхийг тодорхой болгох. Энэ тайлбар нь хуулийн төслийн 29.7. "Захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг энэ хуулийн 29.5.1-29.5.3-т зааснаар үнэлсний дараах үнийг гэрээний үнээр тогтоож, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заана." гэсэнтэй давхардаж байгааг хянаж үзэх	Саналын дагуу өөрчлөлт оруулсан.
76	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		41. 29.6 Хамгийн бага үнэтэй тендерийг шалгаруулдаг одоогийн журам нь энэ заалтад "өсөх дарааллаар эрэмбэлэх" гэсэн нэрээр хэвээр үлдэж байгааг өөрчилж, оролцогчийн ажлын туршлага, техникийн үзүүлэлт, чадавхи, ажил гүйцэтгэх хугацаа зэрэг үзүүлэлтийг харгалзан үзэж үнэлэхээр энэ заалтыг өөрчлөх.	Тендер хянан үзэх шатанд ажлын туршлага, техникийн үзүүлэлт, ажиллах хүчний нөөцийг шалгадаг тул үнэлгээний шатанд дахин уг асуудлыг тусгах шаардлагагүй.
77	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		42. 30.6. Энэ хуулийн 31.3-т заасан үндэслэлээр захиалагч гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгосон бол шаардлага хангасан тендер ирүүлсэн дараагийн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно. "Тендерээс энэ хуулийн 29.6-д заасан эрэмбийн" гэсэн хэсгийг хасах.	Шаардлага хангасан дараагийн оролцогч гэж үзэх талаар тусгайлан заахгүй бол маргаан үүсэх эрсдэлтэй тул эрэмбийг иш татах нь зүйтэй байна.
78	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		43. 31.1. Захиалагч шалгарсан оролцогчтой байгуулах гэрээ баталгаажуулах маягтыг энэ хуулийн 39 дүгээр зүйлд нийцүүлэн боловсруулж, шалгарсан оролцогчид хүргүүлнэ. "тендер шалгаруулалтын баримт бичигт заасан гэрээний нөхцөлд үндэслэн" гэсэн хэсгийг хасах	Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулах боломжгүй тул "Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан гэрээний нөхцөлд үндэслэн" гэснийг хасах боломжгүй.

79	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>44. 39.3. Энэ хуулийн 29.7-д заасны дагуу захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн үнийг залруулсан, үнийн хөнгөлөлт тооцсон, нэг валютад хөрвүүлсэн бол уг үнийг гэрээний үнээр тогтоох бөгөөд гэрээг хэрэгжүүлж эхлэх болон хэрэгжүүлэх явцад ханшийн зөрүү 5 хувиас ихээр дээшээ эсхүл доошоо хэлбэлзвэл гэрээний үнэд ханшийн зөрүүг коэффициентээр тодорхойлж өөрчлөлт оруулна. Энэ заалт нь захиалагч, гүйцэтгэгч нарын аль алины эрх ашгийг ижил тэнцүү хэлбэрээр хамгаалах, гэрээт ажлын үнийг зохиомлоор өсгөх эрсдэлээс хамгаалах тул ийм заалт заавал орох ёстой.</p>	<p>Хуулийн төслийн 41 дүгээр зүйлд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлийг заасан. Түүний дотор тоног төхөөрөмж, материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлс өөрчлөгдөх тохиолдолд гэрээний үнийг тохируулах нэгдсэн системийг захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бол уг нөхцөлд үндэслэн гэрээний үнийг тохируулах боломжийг тусгасан тул саналыг тусгах боломжгүй.</p>
80	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>45. 39.5. Засгийн газрын гишүүний баталсан стандарт нөхцөл нь ерөнхий болон тусгай нөхцөлөөс бүрдэх бөгөөд ерөнхий нөхцөлд захиалагч аливаа өөрчлөлт оруулахгүй. Барилга байгууламжийн ажил гүйцэтгэх гэрээнд олон улсын Фидик-ийн гэрээний жишиг загварыг баримтална. Өнөөдрийн байдлаар Засгийн газрын гишүүний баталсан гэрээний стандарт нөхцөлд захиалагчийн эрх 100 хувь, үүрэг 0 хувь, гүйцэтгэгчийн эрх 0 хувь, үүрэг 100 хувь бүхий гэрээнүүд хийгдэж байгаагаас болж, төсөл цаг хугацаандаа хэрэгжиж дуусахгүй асуудал ихээхэн гарч байгаа тул эрх үүргийг тэгш байлгах зарчмыг хуульчилж өгөх шаардлагатай. Энэ нь захиалагчийн хувьд ч гэсэн төслийн цаг хугацаандаа хүлээн авах боломжийг нэмэгдүүлнэ. Иймд барилга байгууламжийн ажил гүйцэтгэх гэрээнд олон улсын Фидикийн гэрээний загварыг баримтална гэсэн нэмэлт оруулах.</p>	<p>Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлах гэрээний загвар, нөхцөлийг батлахад гадаад улсын болон олон улсын байгууллагын сайн туршлагыг харгалзан үзэх боломжтой тул хуульд заах шаардлагагүй.</p>

81	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>46. 41.2. Нэг эх үүсвэрээс худалдан авахаас бусад аргаар сонгон шалгаруулсан ажил гүйцэтгэх гэрээний дагуу улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөн, шалтгаанаар төсөвт өртгийг хуулиар өөрчлөн баталсан, эсхүл урьдчилан харах боломжгүй гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас ханшийн зөрүү 5 хувиас ихээр дээшээ эсхүл доошоо хэлбэлзвэл талууд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчилж болно.</p>	<p>Хуулиар төсөвт өртгийг нэмэгдүүлсэн тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэхээр заасан нь үнэ өсөхтэй холбоотой шалтгаан ямар ч байх боломжийг олгосон. Иймд төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг хуулиар нэмэгдүүлэх үндэслэлийг тусгайлан заах шаардлагагүй. Төсөвт өртөг нь нэмэгдээгүй бол захиалагч гэрээний үнийг ямарч тохиолдолд нэмэгдүүлэх эрхгүй.</p>
82	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>47. 43.3.2. энэ хуулийн 43.2-т заасан дүнгээс багагүй нэрлэсэн үнэтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаас, Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас, даатгалын гэрчилгээ, хөрөнгийн биржийн баталгаа, үл хөдлөх хөрөнгийн баталгаа, газрын албаны баталгаа зэрэг захиалагчийн шаардлагаар шилжүүлэх эрх бүхий этгээдийн баталгаа. Банк болон даатгалын байгууллагын хооронд өрсөлдөөн бий болгох шаардлагатай байгаа. Олон улсад даатгалын байгууллага батлан даалт гаргах эрхтэй байдаг. Мөн бусад үл хөдлөх, хөдлөх хөрөнгө газрыг эргэлтэнд оруулж баталгаа гаргах боломжийг нээх шаардлагатай.</p>	<p>Захиалагч нь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг барьцаалах, баталгаа авах нь практикт хэрэгжих боломжгүйгээс гадна, түүний чиг үүрэгт үл хамаарна. Харин энэ төрлийн үйл ажиллагааг эрхлэх банк, санхүүгийн байгууллага энэхүү хөрөнгийн үндсэн дээр санхүүгийн эх үүсвэр гаргах нь нээлттэй. Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 43.3.3 дахь заалтад даатгалын гэрчилгээгээр гүйцэтгэлийн баталгаа ирүүлж болохыг заасан байна.</p>
83	"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		<p>48. 43.5. Худалдан авах гэрээний гүйцэтгэл он дамжин үргэлжлэх бол захиалагч гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн үүргийн хэмжээтэй хувь тэнцүүлэн гүйцэтгэлийн баталгааны дүнг бууруулахаар гэрээнд зааж болно. "Хоёр жилээс дээш хугацаагаар" гэснийг "он дамжин" гэж өөрчлөх</p>	<p>Саналыг хүлээн авсан.</p>

84		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		49. 43.6. Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийг дунгийн 5-10 хувийг нэг жилийн хугацаанд саатуулан барих нөхцөлийг захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно. Барилгын тухай хуулийн 14.3-д барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа 1 жил байхаар, мөн хуулийн 14.8-д энэ хугацаанд гүйцэтгэлийг баталгаажуулахаар заасан. Үүний дагуу энэ заалтын "уг хугацаа дуустал" гэснийг " нэг жилийн хугацаанд " гэж өөрчлөх	Саналын дагуу зөвхөн зүгшрүүлэх 1 жилийн хугацаанд уг баталгаа авахаар зааж, баталгааны хувь хэмжээг бууруулан хуулийн төсөлд тусгасан.
85		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		50. 50.4. Үнэлгээний хорооны гишүүдийн 50 хувиас доошгүй нь захиалагчаас хараат бус, тухайн тендерт ашиг сонирхлын зөрчилгүй , хөндлөнгийн гишүүн байна.	Хуулийн төсөлд тусгайлан ашиг сонирхлын асуудлыг зохицуулсан тул давхардуулан тусгах шаардлагагүй байна.
86		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		51. 58.1. Захиалагч тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ зөрчсөн болон Үнэлгээний хороо энэ хуулийг зөрчсөн гэж үзвэл тендерийн нээлтээс өмнө сонирхогч этгээд, тендерийн нээлтээс хойш оролцогч тус тус энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болно.	Үнэлгээний хороо нь захилагчийн эрх, үүргийн бие даан хэрэгжүүлдэггүй тул саналыг тусгах боломжгүй байна.
87		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		52. 60.14.3. зөрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардах, зөрчлийг арилгахыг даалгах	Утгын хувьд давхардал үүсэхээр байх тул саналыг хүлээн авах боломжгүй.
88		"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ		53. " 60.14.4. Захиалагч болон үнэлгээний хорооны хууль бус үйл ажиллагааны улмаас тендерт оролцогчдод учруулсан хохирлыг гаргуулах шийдвэр гаргах. " нэмэх	Уг асуудлыг шүүхээр шийдвэрлэх тул зөвлөлөөс саналд тусгасан шийдвэр гаргах боломжгүй.
89	3	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ	2021.11.11 № 21/22	1. 5.1.2. Монгол Улсын хуулийн дагуу татварын эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй, эсхүл өр төлбөр төлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа; Энэ заалт нь 1 тэрбум төгрөг хүртэл жилийн борлуулалтын орлоготой дотоодын жижиг үйлдвэрлэл эрхлэгчид хамаарахгүй.	Саналын дагуу шалгарсан тохиолдолд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хэмжээний өрийг нөхөн төлөх боломжийг олгохоор хуулийн төслийн тендер хянан үзэх хэсэгт заасан.
90		"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		2. Хуулийн төслийн 7.4 дэх хэсэгт: 7.4.1. Монгол Улсад хог хаягдлыг дахин боловсруулсан эсхүл хэрэглээний хог хаягдлыг дахин боловсруулах боломжтой:	Саналын дагуу "Нийлүүлэх барааны хог хаягдлыг дахин боловсруулахаар эргүүлэн авах санал ирүүлсэн бол" давуу эрх тооцохоор тусгайлан заасан.

91	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		3. 7.4.2. Нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт үйлдвэрлэсэн;	Бараа, материалыг ашигласан гэх агуулгад орон нутагт үйлдвэрлэсэн байх агуулга хамаарах тул саналыг тусгах шаардлагагүй.
92	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		4. 7.4.3. Монгол Улсад үйлдвэрлэсэн эсхүл Монгол улсын иргэн, аж ахуйн нэгжийн оюуны өмчийн эрхтэй инновацийн бүтээгдэхүүн.	Оюуны өмчийн эрхтэй бол нэг үүсвэрээс худалдан авахаар заасан тул тусгайлан саналыг тусгах шаардлагагүй.
93	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		5. 7.4.4. Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй түүхий эд, материал, технологи ашиглаагүй.	Барааны чанар хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бол худалдан авахгүй байх талаар холбогдох бусад хууль тогтоомжид заасан.
94	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		6. 7.4.5. Байгаль орчин, уур амьсгалд сөрөг нөлөөтэй түүхий эд, материал, технологи ашиглаагүй	Захиалагч техникийн тодорхойлолтод энэ тухай заасан бол байгаль орчин, уур амьсгалд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүн худалдан авахгүй талаар заах эрхтэй.
95	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		7. 7.4.6. Ус, эрчим хүчний хэмнэлттэй технологи, ногоон шийдэл ашигласан.	Захиалагч техникийн тодорхойлолтод заахаас гадна үнэлгээний аргыг барааны ашиглалтын зардлаар тогтоосон бол ус, эрчим хүчний хэмнэлтийг тодорхой тогтоож, давуу байдал үүсгэнэ.
96	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		8. 7.6. Энэ хуулийн 7.4-д зааснаар давуу эрх олгоход хангасан шаардлага тутамд дотоодын барааны хэсгийн үнийн 3 хувиар, 7.5-д зааснаар давуу эрх олгоход тендерийн үнийн 7.5 хувиар тус тус тендерийн үнийг хийсвэрээр бууруулж тооцон тендерийн харьцуулах үнийг тодорхойлно	Аль нэг шаардлагыг хангасан нь давуу эрх тооцох үндэслэл болно.
97	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		9. 11.8. Энэ хуулийн 11.7-д заасныг баримтлан "эсхүл түүнийг орлох боломжтой бусад бараа" болохыг оролцогч энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан баримт бичиг болон бусад зохих арга хэрэгслээр нотолсон бол захиалагч техникийн тодорхойлолт хангаагүй гэсэн үндэслэлээр татгалзахгүй.	Саналыг хүлээн авч алдааг залруулсан.
98	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		10. 12.6. Захиалагч шалгарсан оролцогчийн ирүүлсэн тодорхой тооны дээж, загварыг гэрээний хугацаа дуустал хадгалах ба нийлүүлсэн барааны чанар өөрчлөгдөж маргаан үүссэн тохиолдолд анхны дээжийг харьцуулан шинжлэх зорилгоор ашиглана.	Саналыг хүлээн авч холбогдох хэсгийг тусгасан.
99	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		11. 15.2.5 оролцогч этгээдийн санхүүгийн чадавхийг батлан даагч этгээдийн мэдэгдэл, батлан даагчийн санхүүгийн чадавхийг нотлох баримт бичиг. Батлан даагч нь банк санхүүгийн байгууллага иргэн аж ахуйн нэгж байж болно.	Санхүүгийн чадавхийг батлан даах тухай ойлголт байхгүй тул тухайн аж ахуй эрхлэгч өөрийн нэр дээрх хөрөнгө, бэлэн мөнгө эсхүл банкнаас олгох зээлийн эх үүсвэрийг нотолсон байна.

100	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		13. 16.5. Түншлэл гишүүдийн тооноос үл хамааран захиалагчийн тогтоосон техникийн чадавхын доод шаардлагыг хамтдаа бүрэн хангасан байх бөгөөд гишүүн тус бүрийн хангасан байвал зохих техникийн чадавх болон туршлагын шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт заана	Саналыг хүлээн авч өөрчлөн найруулсан.
101	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		14. 19.6. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтад оролцсон, ажлын талбайтай танилцсан сонирхогч оролцогчид давуу байдал олгохгүй.	Төслийн 19.5 дахь хэсгийг хассан тул уг заалтыг тусгах шаардлагагүй.
102	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		15. 35.21. Ерөнхий гэрээ байгуулаагүй 5-аас дээш иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтээр ерөнхий гэрээний тендерийг дахин зарлаж болно. (иргэн оролцох боломжтой байх юм уу)	5-аас бага тооны иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтээр ч ерөнхий гэрээний тендер шалгаруулалт зарлах боломжтой тул тодорхой тоо тавих шаардлагагүй.
103	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		16. 36.11. Үнийн санал цахимаар дуудах үйл ажиллагаанд энэ хуулийн 7.6-д заасан давуу эрхэд тооцно.	Үнийн санал цахимаар дуудах арга нь санал болгосон үнэ гол нөхцөл тул давуу эрх тооцож үнийг хийсвэрээр бууруулж тооцох боломжгүй.
104	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		18. 43.3.4. гэрээний үүрэг гүйцэтгээгүйтэй холбоотой эрсдэлийг батлан даагчийн мэдэгдэл. батлан даагчийн санхүүгийн чадамжийг нотлох баримт бичиг.	Санхүүгийн чадавхийг батлан даах тухай ойлголт байхгүй тул тухайн аж ахуй эрхлэгч өөрийн нэр дээрх хөрөнгө, бэлэн мөнгө эсхүл банкнаас олгох зээлийн эх үүсвэрийг нотолсон байх шаардлагатай тул саналыг хүлээн авах боломжгүй.
105	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		19. 58.1. Захиалагч тендер зарлах шалгаруулахтай холбогдуулан хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзвэл тендерийн нээлтээс өмнө сонирхогч этгээд, тендерийн нээлтээс хойш оролцогч тус тус энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болно.	Тендерийн нээлтээс тодорхой хугацааны өмнө гомдол гаргах талаар заахгүй бол тендер шалгаруулалтын нээлтийг үндэслэлгүйгээр хойшлуулах боломжийг бүрдүүлнэ. Иймд саналыг хүлээн авах боломжгүй.
106	"Монголын гоо сайхны бүтээгдэхүүний кластер" ТББ		20. 62.3. Худалдан авах ажиллагаанд оролцох ажилтан, албан тушаалтан энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь шалгалтаар тогтоогдсон бол тендер хүлээн авах, шалгаруулах, гэрээ байгуулах явцад гарсан зөрчлийг арилгуулж, хохирлыг барагдуулна.	Хохирол барагдуулах асуудлыг Иргэний хууль болон бусад хуулиар зохицуулах тул давхардуулан зохицуулахгүй. Иймд саналыг хүлээн авах боломжгүй.

107	4	"Нийгмийн хөгжлийн ертөнц" ТББ	2021.11.22 № 6	<p>1. 7.3. 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцоно гэсэн нь дотоодын үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг хязгаарласан заалт гэж үзэж байна. Өнөөгийн нөхцөлд 300 сая төгрөгийн өртөг бүхий бараа үйлчилгээг нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжүүд дотооддоо хангалттай олон бий. Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоол "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд дотоодын үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдээ дэмжих, ингэснээр дотоодын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сайжрах, улсад төвлөрүүлэх татвар хураамж нэмэгдэх, тухайн аж ахуйн нэгжид ажиллаж буй ажилчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх зэрэг сайн талууд харагдаж байна. Иймд бараа, үйлчилгээ худалдан авахад гадаадын этгээд оролцох босго үнийг 1 тэрбум болгох саналтай байна.</p>	<p>Саналыг хүлээн авч бараа нийлүүлэх тендер шалгаруулалт оролцох гадаадын этгээдийн оролцох босго үнийг 1.0 тэрбум болгосон. Харин үйлчилгээний салбарт гадаадын этгээд дотоодын этгээдтэй өрсөлдөж байгаа бодит тохиолдол цөөн тул босго үнийг 300.0 сая төгрөгөөс дээш нэмэгдүүлэх шаардлагагүй.</p>
108		"Нийгмийн хөгжлийн ертөнц" ТББ		<p>2. 10.3 Үндсэн хуулийн 8-р зүйл 1.Монгол хэл төрийн албан ёсны хэл мөн. 2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах,соёл урлаг шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө гэж заасан байдаг тул тендерийн хэл Монгол хэл гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр бэлтгэж болно. [Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол түүний аюулгүй байдлыг хангах суурин дээрээс төрийн бух бодлого бодогддог тогтолцоог бий болгоход төрийн албан ёсны хэл чухал юм/ иймээс үндсэн хуулийн заалтыг үндэслэн тендерийн албан ёсны хэл монгол хэл гэж зааж өгөөд гадаадын этгээд оролцох бол монгол хэлнээс гадна олон улсын худалдаанд өргөн хэрэглэдэг хэлээр бэлтгэж болно гэж оруулах саналтай байна.</p>	<p>Төрийн байгууллагын үйл ажиллагаа явуулах хэлийг бие даасан хуулиар зохицуулдаг тул давхардуулан заах шаардлагагүй.</p>

109		"Нийгмийн хөгжлийн ертөнц" ТББ		3. 50.3.Мэдээллийн санд бүртгэлтэй эрх хязгаарлаагүй 5 -аас доошгүй сондгой тооны худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байх ба хувийн хэвшлийн төлөөлөл, эсхүл төрийн бус байгууллагын 2 доошгүй тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцуулна/.Хөндлөнгийн төлөөлөл оролцох тусам татвар төлөгчийн мөнгийг хэрхэн зөв зарцуулж,хянан тавих иргэдийн оролцоог бий болгох,Энэ хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тогтолцоо ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангасан, шийдвэр гаргах ажиллагаанд хариуцлагатай, үр ашигтай, олон нийтийн итгэлийг хангасан байх нөхцөлийг бүрдүүлнэ./	Үнэлгээний хорооны гишүүдийн 1/3-с доошгүй нь хөндлөнгийн гишүүн байхаар заасан тул саналыг тусгасан гэж үзэж байна.
110		"Нийгмийн хөгжлийн ертөнц" ТББ		4. 50. 5 Хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын бусад иргэд оролцох орох эрхийг хязгаарлаж байгаа тул тухайн салбарын болон төрийн бус байгууллага хувийн хэвшил орон нутгийн иргэдийн төлөөллийн эрх нь хязгаарлагдаагүй төлөөллөөс оролцуулна	Саналыг хүлээн авч өөрчлөн найруулсан.
111		"Нийгмийн хөгжлийн ертөнц" ТББ		5. 53.4 Төрийн худалдан авах ажиллагааны газар энэ хуулийн 52.5-д зааснаар мэргэшсэн ажилтны зөрчлийн мэдээллийг хүлээн авсан бол мэргэшсэн ажилтны эрхийг 1 жилийн хугацаанд түдгэлзүүлэх эрхгүй гэж оруулах саналтай байна.	ТХААГ-т мэдээлэл хүргүүлж байгаа зорилго нь мэргэшсэн ажилтны бүртгэлд өөрчлөлт тул саналыг хүлээж авах боломжгүй.
112	5	"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ	2021.10.29 № 2/115	1. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуульд 2019 онд оруулсан 10*1, 10*2 заалтуудыг цаашид үргэлжлүүлэн мөрдөх	Энэ зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.
113		"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ		2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт дотор дотоодын үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний эзлэх хувийг жил бүр 20-30%-иар нэмэгдүүлж,олон нийтэд мэдээлж байх зохицуулалт оруулах	Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтын дагуу худалдан авч буй барааны мэдээллийг захиалагч холбогдох журмын тайлагнах тухай заасан.
114		"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ		3. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтаар үндэсний шинэ технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүнийг дэмжих, старт-ап, ЖДҮ-ийн аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн борлуулалтыг дэмжих зохицуулалт оруулах	Саналыг харгалзан үзэж, хуулийн төслийн холбогдох хэсгүүдэд өөрчлөлт оруулсан.

115		"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ		4. Эх оронч худалдан авалтын хүрээнд урт хугацааны телевлегеет худалдан авалтыг төрийн цахим Дэлгүүрээр дамжуулан төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах зохицуулалтыг боловсронгуй болгон оруулах	Цахим дэлгүүрээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зохицуулалтыг тусгасан.
116		"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ		5. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ЖДҮ-ийн аж ахуйн нэгжүүдийн санхүү, эдийн засгийн чадавхад нийцүүлэн багцлах зохицуулалтыг оруулах	Өрсөлдөөнийг дэмжих зорилгоор тендер шалгаруулалтыг багцад хуваах талаар тусгайлан заасан тул давхардуулан заах шаардлагагүй.
117		"Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл" ТББ		6. Мэргэжлийн холбоодоор дамжуулан төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах зохицуулалтыг оруулах	Худалдан авах ажиллагаатай холбоотой төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх нь төсвийн харилцаа болон холбогдох бусад хууль тогтоомжид харшлах тул саналыг хүлээн авах боломжгүй. Харин төрийн байгууллага, худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагаас зохион байгуулах тендер шалгаруулалтад гишүүнээр оролцох, хөндлөнгийн хяналт тавих эрх нээлттэй болно.
118	6	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ	2021.10.29 № 2/115	1. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт / 3 дугаар зүйл / Хуулийн төсөлд " зөвлөх үйлчилгээ " гэсэн тодорхойлолтыг хассан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 5.1.15 зөвлөх үйлчилгээ " гэж гүйцэтгэгчээс төсөл зохиох, хэрэгжүүлэх, сургалт явуулах, техникийн үзүүлэх, түүнчлэн судалгаа шинжилгээ боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих тусгай мэдлэг, ур чадварын үндсэн дээр үзүүлж байгаа мэргэжлийн үйлчилгээг / -д заасан үйлчилгээг бүр мөсөн хассан мэт харагдаж байгаа тул уг үйлчилгээ нь шинэчилсэн найруулгын аль нэр томъёонд хамааралтай эсэхийг ойлгомжтой болгох. /3.1.1-"ажил 3.1.2- " бараа " ; 3.1.16- " үйлчилгээ " /	Үйлчилгээний тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулсан.
119		"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		2. Хуулийн үйлчлэх хүрээ / 4 дүгээр зүйл / Хуулийн төслийн 4.6 дахь хэсгийн дараа 4.7 " Хувьцааны тавь / 50 / болон түүнээс дээш хувь нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь төрийн болон орон нутгийн өмчөөр худалдан авалт хийх тендерт оролцох эрхгүй " гэж шинээр нэмэх.	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ямар үйл ажиллагааг эрхлэх чиглэлийг тус хуулиар зохицуулах боломжгүй, бие даасан хуулиар зохицуулдаг тул саналыг тусгах боломжгүй.

120	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		3. Худалдан авах ажиллагааны цахим систем / 8 дугаар зүйл Хуулийн шинэчилсэн найруулгын гол зорилго нь худалдан авах ажиллагааны тогтолцоог илүү ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангах, шийдвэр гаргах ажиллагаан дахь хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс хүний оролцоог бууруулж, худалдан авах	Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан эдгээр агуулгын дагуу хуулийн төслийг боловсруулсан.
121	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		4. Техникийн тодорхойлолт / 11 дүгээр зүйл / 1. Хуулийн төслийн 11.7 - д "... эсхүл түүнийг орлох боломжтой бусад бараа д ".... дүйцэхүйц. гэж заасан нь хуулийн 11.1 - ийг зөрчин, чанарын хувьд ижил бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийн шударга өрсөлдөх боломжийг хааж, тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлж, угсардаг аж ахуйн нэгжүүдэд илт давуу тал олгодог. 2. Мөн хуулийн төслийн 11.3 дахь хэсэг аль нэг оролцогчдод илт давуу эрхийг олгож байгаа хасах. Иймээс техникийн тодорхойлолтод үйлдвэрлэгч, барааны тэмдэг, хэлбэр, марк зааж ажлын зураг боловсруулдаг, мөн үйлдвэрлэгч, нийлүүлэгчийг тухайлан заах, " эсхүл түүнтэй дүйцэх " гэсэн тодотголуудыг хасч, техникийн шаардлага, стандартыг заасан байхаар найруулан өөрчлөх. 3. Хуулийн төслийн 11.9 дэх хэсгийн дараа 11.10 " Ажил, үйлчилгээний үр дүнд бий болох аливаа оюуны өмчийн эрхийг захиалагч, эсхүл түүний нэр заасан этгээд эзэмших нөхцөлийг техникийн тодорхойлолтод зааж болно " гэж нэмэх	Захиалагч тодорхой төрлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх талаар шаардлага тавих эрхтэй. Энэхүү эрхийг хязгаарлах нь төрөөс тодорхой бодлого хэрэгжүүлэх, хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах боломжийг хязгаарлана. Иймд саналыг хүлээн авах боломжгүй.
122	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		5. Санхүүгийн чадавхын шаардлага / 15 дугаар зүйл / Хуулийн төслийн 15.2.4 ; 16.2.1 ; 16.2.2 дахь хэсэгт сүүлийн 5 хүртэл жилийн.... " гэснийг ".... сүүлийн 2 жилийн.... " гэж өөрчлөн, оролцогчдын тоог үл хязгаарлаж, тэгш өрсөлдөх боломж олгох.	Саналын дагуу хугацааг багасгаж 3 хүртэл жил байхаар тусгасан.
123	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		6. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах / 18 дугаар зүйл / Хуулийн төслийн 18.3 дахь хэсгийг " Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас ажлын 5 - аас доошгүй хоногийн өмнө тендер баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно " гэж найруулах	Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулах эрхийг хоног хугацаагаар хязгаарлах нь хэт явцуурсан болно. Иймд ажлын 5 хоногийн дотор нэмэлт, өөрчлөлт оруулсан бол хугацааг зохих ёсоор сунгах тухай санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 20.3 дахь хэсэгт заасан.

124	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		7. Захиалагч шийдвэр гаргах хугацаа / 24 дүгээр зүйл / Хуулийн төслийн 24.3 дахь хэсгийн дараа 24.4 " Энэ хуулийн 24.3 - д зааснаар тендерийн хугацааг сунгасан бол захиалагч бүх оролцогчдод бичгээр мэдэгдэж, энэ хугацаанаас өмнө тендерийн хүчинтэй байх хугацаа нь дуусгавар болох нөхцөл үүссэн оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг захиалагчид хүргүүлнэ ” гэж нэмэх	Захиалагч шийдвэр гаргах хугацаа сунгасан үндэслэлээр оролцогчдод мэдэгдэж, хугацаа сунгах хүсэлт гаргах тухай заасан.
125	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		8. Өрсөлдөөнт хэлэлцээний арга / 37 дугаар зүйл Хуулийн төслийн уг зүйл, заалт 37.1.1 ; 37.1.2 дахь заалт нь худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шударга, үнэн зөв зохион байгуулах зарчмыг алдагдуулах тул хасах саналтай байна. Учир нь, төсөлд худалдан авах ажиллагаа / тендер / зохион байгуулах хугацааг 2 дахин богиносгосон. Гэрээ шууд байгуулах аргыг боловсронгуй болгох гэдэгт дээрх зүйл, заалт багтаж байгаа эсэхийг тодорхой болгох	Гэрээ шууд байгуулахаар хуульд заасан зохицуулалтыг багасгаж өрсөлдөөн нэмэгдүүлэх, аж ахуй эрхлэгчийн оролцоог хангах шаардлагаар уг тендер шалгаруулалтын аргыг шинээр тусгасан тул саналыг хүлээн авах боломжгүй.
126	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		9. Тендерийн болон гүйцэтгэлийн баталгаа Хуулийн төслийн 43 дугаар зүйл “ Гүйцэтгэлийн баталгаа ”, 44 дүгээр зүйл " Урьдчилгаа төлбөрийн баталгаа ” нь гүйцэтгэгчдийн хувьд санхүүгийн том дарамт болдог тул тендерт ялсан тохиолдолд Тендерийн баталгааг шууд гүйцэтгэлийн баталгаа болгож шилжүүлдэг болгон өөрчлөх. Ингэснээр олон компанийн хувьд тэгш ил тод өрсөлдөх боломж илүү нээгдэж, санхүүгийн хувьд гүйцэтгэгчид дэмжлэг болох юм.	Тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгааны нөхцөл, зориулалт, хугацаа нь ялгаатай тул тендерийн баталгааг шууд гүйцэтгэлийн баталгаа болгох боломжгүй. Чөлөөлөгдсөн тендерийн баталгааны эх үүсвэрийг гүйцэтгэлийн баталгаанд шилжүүлэх эрх нь оролцогчид нээлттэй болно. Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 44.3 дахь хэсэгт гүйцэтгэлийн баталгааны дүнг урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд оруулан тооцох зохицуулалт тусгагдсан.
127	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		10. Захиалагчийн шийдвэрт гомдол гаргах / 60 дугаар зүйл / Хуулийн төслийн 60.14.3 дэх заалтын дараа : -60.14.4 гомдол гаргагчийн гомдол үндэслэлтэй бол гомдол гаргагчтай гэрээ байгуулахыг даалгах ; - 60.14.5 захиалагч болон үнэлгээний хорооны хууль бус үйл ажиллагааны улмаас тендерт оролцогчдод учруулсан хохирлыг гаргуулах шийдвэр гаргах ; -60.14.6 захиалагч болон үнэлгээний хорооны шийдвэр хууль бус эсхүл хүчин төгөлдөр бус болохыг тогтоох, гэж нэмэх	Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар зөвлөлийн гаргах шийдвэр нь гэрээ байгуулахыг даалгах, хохирол нөхөн төлүүлэхээр шийдвэрлэх нь шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудал тул саналыг тусгах боломжгүй.

128	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		11. Хариуцлага Захиалагч, үнэлгээний хороо, гишүүд, оролцогчдыг хариуцлагажуулах талын зүйл, заалтыг тодорхой тусгах	Саналын дагуу үнэлгээний хорооны гишүүд болон захиалагч хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг нэмэгдүүлсэн.
129	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		12. 1.1 Энэ хуулийн зорилго нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд ил тод шударга ёс, өрсөлдөх тэгш боломжийг хангах захиалагч, гүйцэтгэгч тэгш эрх, үүрэгтэй хариуцлагатай байх, гэрээний чөлөөт байдлын зарчмыг баримтлах, үр ашигтай, олон нийтийн итгэлийг хангасан байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.	Гэрээний харилцааг хуулийн төслийн холбогдох хэсэгт зохицуулах тул зорилгод оруулах шаардлагагүй.
130	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		13. 5.1.2 Монгол Улсын хуулийн дагуу өмнөх жилийн татварын эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй, эсхүл өр төлбөр төлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа	Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 5.1.2-т хугацаа хэтэрсэн өртэй эсэхийг оролцогчийн ерөнхий нөхцөлийг шалгахад харгалзан үзэхээр тусгасан. Түүнчлэн шалгарсан тохиолдолд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хэмжээний өрийг нөхөн төлөх боломжийг олгохоор хуулийн төслийн тендер хянан үзэх хэсэгт заасан.
131	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		14. 5.1.5 Захиалагч болон үнэлгээний хороо, түүний гишүүд нь оролцогч, түншлэлийн гишүүнтэй Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6 - д заасан харилцан хамааралтай, эсхүл үгсэн хуйвалдсан гэж үзэх бодит үндэслэл байгаа ;	Өрсөлдөөний тухай хуульд заасан харилцан хамаарлыг тогтоох нь оролцогчид өөр хоорондоо хамааралгүй, үгсэн хуйвалдаагүй байх агуулгыг илэрхийлж байна. Захиалагч, түүнийг төлөөлж буй нийтийн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1 дэх хэсэгт зааснаар хамааралтай бол ерөнхий шаардлага хангахгүй болохыг тусгайлан заасан.
132	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		15. 6.4 Тендерт гадаадын хуулийн этгээд шалгарсан тохиолдолд Монгол Улсад хуулийн этгээд байгуулсны үндсэн дээр үүрэг гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно.	Гадаадын этгээдээс бүрдсэн түншлэл шалгарсан байх тохиолдолд Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг оролцуулан гэрээ байгуулна.

133	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		16. 10.1 Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, гэрээний маягт болон холбогдох бусад хууль, журам, аргачлалын дагуу боловсруулна. Гэрээний маягт нь гэрээний чөлөөт байдлын зарчимд үндэслэж гэрээ байгуулагч талуудын санал өгөх эрхийг хязгаарлахгүй байна.	Тендерийн нээлтээс өмнө гэрээний нөхцөлийг тодруулах нь нээлттэй. Гэрээний нөхцөл болон гэрээний талаар албан бичгээр тендер шалгаруулалтад оролцохоос өмнө хүргүүлж, саналаа тусгуулах боломжтой тул саналыг тусгах шаардлагагүй.
134	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		17. 11.3 нь 11.5-тай зөрчилдөж байна.	Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 11.3 дахь хэсэг нь тухайн бараа, ажил, үйлчилгээний үйлдвэрлэлийн процесс, хөдөлмөрийн нөхцөл, хог хаягдлын менежмент зэргийг харгалзан үзэх талаар зохицуулсан тул 11.5 дахь хэсэгт зааснаас өөр ойлголт болно.
135	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		18. 17.3.2. бараа, ажил, үйлчилгээний товч агуулга, тендер зарлах үеийн зах зээлийн үнэ, ханшаар бодитой тооцсон төсөвт өртөг.	Төсөвт өртгийг зохион асуудлыг бие даасан хуулиар зохицуулдаг тул тус хуулийн дагуу тооцож, холбогдох эрх бүхий этгээдийн баталсан төсөвт өртөгт үндэслэхээс өөр аргагүй байна.
136	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		19. 15.2.4 сүүлийн 2 хүртэл жилийн хугацаанд оролцогчийн тухайн бараа, ажил, үйлчилгээнд болон салбарт хэрэгжүүлсэн борлуулалтын орлогын мэдээлэл.	Саналыг харгалзан үзэж 3 хүртэл жил байхаар тогтоосон.
137	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		20. 24.2. Тендер шалгаруулалтын гомдол шийдвэрлэх зөвлөлөөс энэ хуулийн 60.14-д заасан шийдвэрийг гаргасантай холбоотойгоор захиалагч энэ хуулийн 24.1-д заасан хугацааг ажлын 10 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.	Саналыг хүлээн авсан.
138	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		21. 21.3 Оролцогч өөрийн тендерийн хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтээ бичгээр болон цахимаар Захиалагчид хүргүүлэх ба ийнхүү сунгаагүй нь түүний тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болохгүй.	Хуулийн төсөлд цахим системээр харилцсан харилцааг бичгээр харилцсан гэж үзэхээр заасан тул цахим шуудангаар харилцах хэлбэрийг бичгээр харилцсан гэж үзэх эрх зүйн боломж одоогоор байхгүй тул тусгах боломжгүй.
139	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		22. 24.3 Тендер шалгаруулалтын гомдол шийдвэрлэх зөвлөлөөс энэ хуулийн 60.12-д заасны дагуу гомдлыг хянах шийдвэр гаргасантай холбоотойгоор захиалагч энэ хуулийн 24.1-д заасан хугацааг ажлын 15 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.	Захиалагч шийдвэр гаргах хугацааг хуульд заасан тул дахин үнэлэх хугацааг өмнөх хугацаатай тэнцүү хугацаагаар дахин тогтоох нь төсөл, арга хэмжээний шийдвэр гаргах хугацааг удаашруулах сөрөг талтай тул саналыг хүлээн авах шаардлагагүй.

140	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		23. 27.2.4. холбогдох гэрээний нөхцөлөөр тодорхойлсон талуудын эрх, үүргийг хүлээн зөвшөөрсөн байх;	Гэрээний нөхцөлийг захиалагч тодорхойлж, тендер шалгаруулалтын баримт бичигт тусгадаг тул саналыг хүлээн авах боломжгүй.
141	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		24. 28.2 Оролцогч энэ хуулийн 28.1 - д заасан тайлбар авах тухай тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор холбогдох тайлбарыг захиалагчид хүргүүлнэ	Тендер шалгаруулалтын арга тус бүрд хариу авах шаардлагатай хугацаа өөр шаардлагатай тул хуульд тусгайлан ижил хоног заах боломжгүй байна.
142	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		25. 27.8-ыг хасах	Нэгэнт шаардлагад нийцээгүй татгалзах тул тодорхой хэвээр үлдээх нь зүйтэй байна.
143	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		26. 30.5 нь 31.3-тай уялдахгүй байна.	Саналын дагуу техник алдааг залруулав.
144	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		27. 43.6 Бараа ажил үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 1-5 хувийг уг хугацаа дуустал саатуулан барих нөхцөлийг захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.	Саналыг тусгалаа.
145	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		28. 50.3 Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд 53.2 т зааснаар мэдээллийн санд бүртгэлтэй үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах эрх хязгаарлаагүй 3 - аас доошгүй сондгой тооны худалдан авах ажиллагааны болон тухайн тендертэй холбоотой мэргэжлээр мэргэшсэн ажилтныг томилно.	Саналын дагуу өөрчлөлт орууллаа.
146	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		29. 50.4 Үнэлгээний хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь захиалагчаас хараат бус, тухайн тендерт ашиг сонирхлын зөрчилгүй, хөндлөнгийн гишүүн байна	Хуулийн төсөлд тусгайлан ашиг сонирхлын асуудлыг зохицуулсан тул давхардуулан тусгах шаардлагагүй байна.
147	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		30. 58.1 Захиалагч тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ зөрчсөн болон Үнэлгээний хороо энэ хуулийг зөрчсөн гэж үзвэл тендерийн нээлтээс өмнө сонирхогч этгээд, тендерийн нээлтээс хойш оролцогч тус тус энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болно.	Үнэлгээний хороо нь захилагчийн эрх, үүргийн бие даан хэрэгжүүлдэггүй тул саналыг тусгах боломжгүй байна.
148	"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		31. 58.5-ыг хасах.	Саналын дагуу хассан.

149		"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		32. 60.14.1 захиалагчийн шийдвэр буюу үйлдлийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөлт оруулах, илт хууль бус болохыг тогтоох ;	Саналыг хүлээж авав.
150		"Эрчим хүчний зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ		33. 60.14.3 зэрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардах, зэрчлийг арилгахыг даалгах,	Утгын хувьд давхардал үүсэхээр байх тул саналыг хүлээн авах боломжгүй.
151	7	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим	2021.11.12 № 01/800	1. Хуулийн төслийн 60 дугаар зүйлийн 60.6. "Энэ хуулийн 60.5 - д зааснаар түдгэлзүүлсэн хугацаанд захиалагч шийдвэр гаргахад баримтлах энэ хуулийн 24.1-д заасан хугацаа тоолохыг зогсооно. ", 61 дүгээр зүйлийн 61.1. "Зөвлөл энэ хуулийн 60.6 - д заасан хугацаанд шийдвэрлээгүй эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрсөн тухай гомдлыг шүүхэд гаргаж болно " гэж тус тус заажээ. Гэтэл төслийн 60.5 дах хэсэгт тодорхой хугацаа бичигдээгүй байна. Төслийн 24.1 - т заасан хугацаа Захиалагчаас тендерийг хянан үзэх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох ажиллагаа хийх хугацаа байгаа тул Зөвлөлийн гомдол хянан шийдвэрлэх хугацааг заах, заасан заалтыг шүүхэд гомдол гаргах хэсэгт иш татах шаардлагатай	Зөвлөл гомдол хянан шийдвэрлэх хугацааг ажлын 10 хоногоор хязгаарлах тул ойлгомжтой байна.
152		Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		2. Тендерийн урилга, ТШӨХ, техникийн тодорхойлолтын ерөнхий шаардлага дээр зарим заалт шаардлагууд зөрүүтэй, мөн ОГТ шаардлагагүй байхад тусгай зөвшөөрөл болон нотлох баримтууд (заавал захиалагчийн нэр дээр гэрээ хэрэгжүүлсэн тухай тодорхойлолт авсан байх, эсвэл тендер зарласан өдрөөс хойш захиалагч байгууллагаас тодорхойлолт авсан байх гэх мэт) шаарддаг. Хуулийн төсөлд тендерт бэлтгэх хугацаа 7 хоног хүртэл багассан хэрнээ тодруулга авах, өгөх хугацаа 18.1 болон 18.2 - т, 18.3 - т зааснаар тендер хүлээн авахаас хэдэн цагийн өмнө ч хамаагүй захиалагч ТББ - даа өөрчлөлт оруулж болох нөхцөл бүрдэж байгаа нь бэлтгэх хугацаа хангалтгүй болгож байгааг анхаарах хэрэгтэй.	Хуулийн төсөлд нээлттэй тендер шалгаруулалтын аргын үед тендер хүлээн авах хугацааг ажлын 15 хоног байхаар өөрчилсөн. Хэрэв захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол нээх хугацааг өөрчлөлт оруулсан өдрөөс хойш ажлын 5 хоног байхаар заасан. Түүнчлэн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гэрээг гүйцэтгэхэд ач холбогдолтой шаардлага тавихгүй байхаар тусгасан.

153	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		3. Хуулийн төслийн заалтаар нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хуваан зохион байгуулж болно гэж оруулсан нь асуудлыг шууд шийдвэрлэж чадахгүй юм. Иймд барааны төрөл шинжээр нь тодорхойлж тендерийг зарлах үүрэг болгосон шинжтэй зохицуулалт шаардлагатай. Ингэснээр олон оролцогчид тендерт оролцон, өөрсдийн худалдан борлуулдаг хамгийн тохирохуйц боломжит барааг санал болгосноор худалдан авах ажиллагаанд эерэг үр дүн авчирна.	Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 9.5 дахь хэсэгт "зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар" нь багцлахаар заасан тул саналыг хүлээн авах боломжгүй.
154	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		4. Тендерийн мэдэгдэл дээр шалгараагүй үндэслэлийг захиалагчийн шаардлага болон оролцогчийн саналыг харьцуулсан байдлаар гаргаж, шаардлага хангаагүй үндэслэлийг тодорхой хүргүүлдэг байх хэрэгтэй.	Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 30.2 дахь хэсэгт захиалагчийн шийдвэрт шалгараагүй болон татгалзсан үндэслэлийг заахаар тусгасан бөгөөд уг шийдвэр нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны актын холбогдох шаардлагыг хангасан байхыг хуулиар шаарддаг болно.
155	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		5. Үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг Маягт 4-ийн дагуу гэж шаарддаг ба зөвхөн өөрийн маягтын дагуу зөвшөөрлийн бичгээ явуулдаг олон улсад танигдсан дэлхийн ТОМООХОН үйлдвэрлэгчид нэлээдгүй байдгийг харгалзан үзэх шаардлагатай байна.	Хуулийн төсөлд үйлдвэрлэгчийн зөвшөөрөл ирүүлэх талаар тусгагдаагүй байна.
156	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		6. Зарим тендер шалгаруулалт тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө үзүүлэн бараа ирүүлсэн байхыг шаарддаг нь тухайлсан бараа нөөцөд бэлэн байхгүй үед өрсөлдөөнийг хязгаарласан заалт болдог тул анхаарч үзэх хэрэгтэй.	Тендер шалгаруулалтын баримт бичигт дээж хэзээ ирүүлэхийг заахаар хуулийн төсөлд тусгасан байна.
157	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		7. Цахимаар авч болдог тодорхойлолтуудыг тендерт шаардахгүй байх, Жишээ нь: Нийгмийн даатгалын тодорхойлолт, Татварын тодорхойлолт, Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт, ЗХАШШүүхийн тодорхойлолт, ШШГЕГ - ын тодорхойлолт, Улсын бүртгэлийн гэрчилгээ, Санхүүгийн болон аудитын тайлангууд гэх мэт. Мөн иргэний үнэмлэх, байгууллагын тодорхойлолт албан бичиг, цахим системүүдээс гардаг бичиг баримтуудыг нотариаттай ирүүлэхийг шаарддагийг халах цаг болсон.	Хуулийн төсөлд тусгагдсан.

158	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		8. Тендерт ирүүлж байгаа бүх материалыг орчуулгатай ирүүлэхийг шаарддаг. Энэ нь олон бараатай, дан техникийн үзүүлэлттэй олон хуудас бүтээгдэхүүний танилцуулга, дата хүснэгт зэрэг техникийн үг хэллэгтэй материалууд нь орчуулагдахгүй үг хэллэг ихтэй, хүндрэлтэй, орчуулах шаардлагагүй бөгөөд хугацаа их орсон ажил болдог.	Хуулийн төсөлд тухайн бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлд ач холбогдол бүхий баримт бичгийг ирүүлэхээр тусгагдсан тул уг асуудлыг хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд хязгаарлах боломжтой байна.
159	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		9. Хуудас бүрийг үсгээр баталгаажуулахыг шаарддаг бүтээгдэхүүний танилцуулгатай нэг хуудас материал баталгаажуулахгүй шалтгаанаар унагадаг. Нэгэнт тоон гарын үсэг ашиглаж цахим тендерт оролцож байгаа бол тоон гарын үсэг гэсэн утгаар хэрэглээнд нэвтрүүлэх шаардлагатай байна.	Хуулийн төсөлд тусгагдсан.
160	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		10. Цахим системд захиалагч тодруулга оруулалгүйгээр тендерийн баримт бичгийн шаардлагыг өөрчилж дахин оруулснаас болж оролцогч түүнийг мэдэлгүй тендерт орж унах тохиолдол гардаг тул зөвхөн тодруулга хэсэгт өөрчлөлт хийж болдог, анхны ТББ, ТЭЗҮ-ийг өөрчлөх боломжгүй байхаар тохируулан оруулж өгөх шаардлагатай.	Тендерийн нээлтээс өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийг цахим системд нийтэлж мэдэгдэхээр зааж, шаардлагатай хугацаагаар хүлээн авах хугацааг хойшлуулахаар зохицуулалтыг тусгасан.
161	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		11. Захиалагчид нь тендерт оролцогчдын чадавхийг үнэлэх үндсэн шалгуурыг өөрсдийн үзэмжээр, ажил үйлчилгээний чанарт сөрөг нөлөөлж болохуйц хэт сул, мөн тухайн ажилд чухал биш хирнээ тендерт оролцогчдод хэт хүндрэлтэй заалтуудыг ТШӨХ-д тусгаж байна. Жишээ нь: Тухайн ажилд шаардлагагүй мэргэжилтэн, тоног төхөөрөмж, тодорхойлолт шаардах (сантехникийн инженер шаардсан хирнээ, дулаан, цэвэр бохир ус, агаар сэлгэлтийн инженер давхар шаардах, сантехникийн засварын ажилд холбооны инженер шаардах, хувийн хэвшил хариуцагчаар ордоггүй захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт шаардах гэх мэт)	Хуулийн төсөлд тухайн бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлд ач холбогдол бүхий баримт бичгийг ирүүлэхээр тусгагдсан тул уг асуудлыг хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд хязгаарлах боломжтой байна.

162	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		12. Мөн өрсөлдөөнийг хязгаарласан шинжтэй заалтууд их оруулдгийг болих хэрэгтэй. Тухайлбал: ТӨБЗГ-аас зарласан зарим барилгын тендерүүдэд түрээсээр цөөн хоног ашиглах боломжтой ковш 10 тн-с дээш кран, 20 тн-с дээш ачааны машин - 2 ш гэх мэт техникүүдийг заавал оролцогчийн өөрийн байх гэж заасан байдаг. Энэ нь тендерийн тухай хуулийн гол зарчим болох өрсөлдөх тэгш боломжийг хангах, үр ашигтай байх гэсэн суурь зарчмаасаа гажиж байна. Иймээс том техникүүдийг 100 хувь түрээслэх боломжтойгоор тусгах хэрэгтэй.	Хуулийн төсөлд тухайн бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлд ач холбогдол бүхий баримт бичгийг ирүүлэхээр тусгагдсан. Түүнчлэн холбогдох хуулиар тусгай зөвшөөрөл эзэмшигчид байх тоног төхөөрөмжийн шаардлагыг заасанд нийцүүлэн захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.
163	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		13. ИТА, машин техник тоног төхөөрөмж давхцаагүй байх ёстой гэсэн шаардлагыг хасах, хугацааны хувьд зөрүүтэй ажлууд болон, бага хэмжээтэй ажлуудад давхардах боломжтой байна.	Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагын дагуу аж ахуйн эрхлэгчийн нөөц бололцооноос хэтэрсэн гэрээ хэрэгжүүлэх эрхийг олгох боломжгүй.
164	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		14. 5.1.5 Захиалагч болон үнэлгээний хороо, түүний гишүүд нь оролцогч, түншлэлийн гишүүнтэй Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай, эсхүл үгсэн хуйвалдсан гэж үзэх бодит үндэслэл байгаа;	Өрсөлдөөний тухай хуульд заасан харилцан хамаарлыг тогтоох нь оролцогчид өөр хоорондоо хамааралгүй, үгсэн хуйвалдаагүй байх агуулгыг илэрхийлж байна. Захиалагч, түүнийг төлөөлж буй нийтийн албан тушаалтан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1 дэх хэсэгт зааснаар хамааралтай бол ерөнхий шаардлага хангахгүй болохыг тусгайлан заасан.
165	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		15. Гомдол хянан үзэх зөвлөл, Сангийн яамны эрхийг нэмэгдүүлэх. Өөрөөр хэлбэл буруу шалгаруулсан тохиолдолд зөвлөмж заавар өгч захиалагч руу буцаах биш, тендерийн үнэлгээг хийж үр дүнг нь шууд гарган, хууль бус үйлдэл гаргасан үнэлгээний хорооны багийн гишүүдэд хатуу хариуцлага тооцох, тендер шалгаруулалтад тухайн тойргийн УИХ-ын гишүүд нь нөлөөлдийг болиулах нь зүйтэй. Сангийн яамнаас үнэлгээг дахин хийж, холбогдох хүмүүст хариуцлага тооцож хариу мэдэгдэхийг захиалагчид даалгасан албан тоот хүргэдэг ч захиалагч түүнийг нь тоолгүй тендерийн хүчинтэй хугацааг дуусгаж дахин тендерээ зарласан тохиолдлууд гардгийг анхаарах шаардлагатай.	Захиалагч, үнэлгээний хороонд аливаа этгээд нөлөөлөхийг хуулиар хориглодог. Зөвлөлийн гаргах шийдвэрийн төрлийн хувьд гэрээ байгуулах захиалагчийн эрхийг эдлэхгүй тул саналыг дагуу өөрчлөлт оруулах боломжгүй. Харин зөвлөлөөс гаргасан шийдвэртэй холбоотойгоор дахин үнэлгээ хийж, шийдвэр гаргаагүй бол уг тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхгүй байхаар хуулийн төсөлд тусгасан.

166	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		16. Инженер техникийн ажилчдын тухайн мэргэжлээр гүйцэтгэх үндсэн үүрэг чиглэлийг харгалзан үнэлгээг хийх. Жишээ нь: ТШӨХ - д халаалт, агаар сэлгэлт, дулаан, цэвэр бохир усны инженер заасан байхад 2005 оноос өмнө сантехникийн инженерийн мэргэжлээр төгссөн инженерийг тендерт тэнцэхгүй Сантехникийн инженерийн хийж гүйцэтгэх ажил мэргэжлийн тодорхойлолтод дээрх бүх ажилбарууд багтдаг, практикт ч эдгээрийг хийж гүйцэтгэдэг.	Салбарын хууль тогтоомжоор зохицуулах боломжтой байна.
167	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		17. Шалгарсан компанийн материалыг оролцогчдын хүсэлтийг хүлээхгүйгээр шууд оролцогчдод ил болгох, хэвшүүлэх хэрэгтэй.	Оролцогчийн хүсэлтэд үндэслэхгүйгээр оролцогчид гэрээ байгуулах эрх авсан оролцогчийн тендертэй танилцдаг.
168	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		18. Үнэлгээний хорооны гишүүд, энэ чиглэлээр хяналт тавьдаг байгууллагын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хууль бус үйлдлийнхээ төлөө хүлээх хариуцлагыг нь тодорхой болгож, хариуцлагыг чангатгахаар хуульд тусгаж хэрэгжилтэд хяналт тавих. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн, хэрэгжүүлдэггүй шат шатны албан тушаалтнуудыг тухайн албан тушаалаас нь чөлөөлөхөөр хуульд тусгах шаардлагатай.	Саналын дагуу хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтан, ажилтныг үүрэгт ажлаас нь халах хариуцлага ногдуулахаар хуулийн төсөлд тусгасан.
169	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		19. 13.8. Тендерийн үнийн алдаа нь Захиалагчаас шалтгаалсан нөхцөл байдал бөгөөд оролцогч үнийн алдааг шууд хүлээн зөвшөөрөхийг тулгаж, эс бөгөөс тендерийн баталгааг улсын орлого болгохоор заасан нь шударга бус байна.	Захиалагчаас шалтгаалсан тохиолдлоор үнэд аливаа алдаа үүсэх боломжгүй бөгөөд оролцогчийн ирүүлсэн үнэд арифметик үйлдлийн алдаа байгаа эсэхийг шалган үнэлэх тул саналыг тусгах боломжгүй.
170	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		20. 14.3. "Гэрээг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, үйлдвэрлэгчийн итгэмжлэл эсхүл мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэх шаардлагатай бол захиалагч энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана." гэж өөрчлөн найруулах;	Үйлдвэрлэгчтэй байгуулсан хэлцлийг зөвхөн итгэмжлэлээр нотлох нь учир дутагдалтай байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй.

171	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		21. 33.2. Нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 хоног байсныг 7 ба түүнээс дээш хоног болгож өөрчилсөн атлаа тодруулга авах гаргах, түүнийг нийтлэх хугацаа өөрчлөгдөөгүй, гомдол гаргах хугацаа бас богино болсон байна. Үнийн дүнгээс хамаарч ялгаатай хугацаа тавих эсвэл хугацааг дор хаяж 15 хоног болгохгүй бол өндөр үнийн дүнтэй, олон төрлийн бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, мэргэжилтнүүдийн ур чадвар ихээхэн шаардагддаг тендерийн хувьд хангалтгүй хугацаа байна.	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
172	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		22. 39.5. Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээтэй холбоотой харилцаа нь Иргэний хуульд заасан Захиалагч, зарчим, үндэслэл, журмын дагуу зохицуулагдах тул гэрээний нөхцөлийн талаар талууд харилцан тохиролцож, аль аль талд ашигтай хууль болон талуудын эрх ашгийг зөрчөөгүй хэмжээнд гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах боломжтой байх ёстой.	Гэрээний нөхцөлийг захиалагч тодорхойлж, тендер шалгаруулалтын баримт бичигт тусгадаг тул саналыг хүлээн авах боломжгүй.
173	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		23. 60 дугаар зүйлийг хасах саналтай байна. 60.12. Төслийн 60.13. Энэ хуулийн 60.12-т зааснаар гомдлын хүрээнд хянах нь захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулахад энэ хуульд заасан журмыг баримталсан эсэхийг хянахыг хязгаарлах үндэслэл болохгүй гэж орсон буй хэдий ч 60.12 дахь заалтын дагуу зөвхөн гомдолд дурдсан асуудал, үндэслэлийн дагуу хянагдаж, 60.13 дахь заалтын хэрэгжилтийг хангахгүй орхих эрсдэлтэй.	Шалгарсан оролцогчийн шаардлага хангах эсэх талаар зөвхөн бусад оролцогчийн гомдлын үндэслэлд үндэслэх нь зөвлөл өөрийн дур зоргын үндсэн дээр шийдвэр гаргах, тендер шалгаруулалтын эцсийн үр дүнд нөлөөлөх боломжийг хязгаарлана. Харин тендер хянан үзэх, үнэлэхээс бусад асуудлаар захиалагчийн илтэд хууль зөрчсөн нөхцөл, байдлыг гомдол гаргагч мэдээгүй, мэдэх боломжгүй байхыг үгүйсгэхгүй тул уг асуудлаар хянан шийдвэрлэхийг хязгаарлаагүй болно.
174	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		24. 60.16. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль заасан тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй гэдэг лимитийг үргэлжлүүлэн мөрдөх саналтай.	Тендерийн баталгааг улсын орлого болгож байгаа хэмжээг тендер шалгаруулалтын цар хүрээтэй уялдуулах нь аль ч түвшний оролцогчийн хувьд шударга байдлыг хангана.

175		Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		25. Төслийн 60.4 дэх заалтын дагуу гомдлыг шууд буцаалгүйгээр, гомдол гаргах эрх бүхий оролцогчоос зөвлөлд гаргах гомдлын бүрдүүлбэрийг хянаад, түүний үндсэн дээр тендерийн баталгааны шаардлагыг хангуулах арга хэмжээг авдаг байх.	Шүүхийн адил бүрдүүлбэрийн шаардлага хангуулах хугацаа тогтоох нь худалдан авах ажиллагааг сунжруулах, гомдол гаргагчийн хариуцлагагүй байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Иймд саналыг хүлээн авах боломжгүй.
176		Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		26. 61.1.Зөвлөл нь тендерт оролцогчийн гомдлыг энэ хуулийн 60.6-д заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл Зөвлөлийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл тендерт оролцогч нь шүүхэд гомдол гаргаж болно.	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
177		Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим		27. Захиалагчийн буруутай үйлдлийн улмаас оролцогч тендерт шалгараагүй, оролцогч маргаан үүсгэж, шүүхээр Захиалагчийн хууль бус үйлдлийг тогтоосон ч хэдийн гэрээ байгуулагдсан бол Захиалагчаас тодорхой хэмжээний нөхөн төлбөр оролцогчид олгох, эсхүл гаргасан зардлыг нөхөн төлүүлэх нь зүйтэй.	Хохирол барагдуулах асуудлыг Иргэний хууль болон бусад хуулиар зохицуулах тул давхардуулан зохицуулахгүй. Иймд саналыг хүлээн авах боломжгүй. Харин хуулийн төсөлд заасан хугацаанд огт шийдвэр гаргаагүй бол холбогдох зардлыг нөхөн төлөх боломжтой талаар хуулийн төсөлд тусгасан.
178	8	Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" ТББ	2021.11.19, 117	1. Хуулийн төслийн 7.3 дахь хэсэг: Захиалагч 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно гэсэнд эм, эмнэлгийн хэрэгслийн тендерт оролцдог манай гишүүдийн хувьд бараа, үйлчилгээний үнийн дүнг 3,0 тэрбум болгох саналтай байна. Учир нь нэг эмнэлгийн төсөвт тендер 500 сая төгрөгөөс дээш байдаг нь дотоодын эм хангамжийн компаниуд оролцож гадны эмийн фирмүүдтэй өрсөлдөх боломжгүй болно.	Саналын дагуу барааны босго үнийг нэмэгдүүлж 1 тэрбум болгосон.
179		Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" ТББ		2. Хуулийн төслийн 7.5.1 дэх заалт: 50-аас доошгүй хувийг нь Монгол Улсын нэг эсхүл хэд хэдэн иргэд шууд, эсхүл шууд бусаар өмчилдөг Монгол Улсын хуулийн этгээд гэсэн заалт нь гадаадын хөрөнгө оруулалтыг татаж Үндэсний эм үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, улмаар тендерт тэгш эрхийг хангаж ажиллахгүй болох тул энэхүү заалтыг хасах саналтай байна.	Уг давуу эрхийн нь зөвхөн ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтад хамаарах тул саналыг тусгах шаардлагагүй.

180		Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн "Эм" ТББ		3. Энэхүү хуулийн төсөлд захиалагчийн санхүүгийн хариуцлагын талаар нэг ч заалт алга байна. Эм хангамжийн компаниуд эмнэлгийн байгууллагуудад захиалгын дагуу эм бараа өгсөн ч төлбөрөө өгөхгүй, он дамжуулан өр авлага үүсгэж байна. Энэ нь компанийн санхүүг хүнд байдалд оруулж байна.	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
181	9	"Монголын авто замчдын холбоо" ТББ	2021.11.22, А-326	1.Ажлаа гүйцэтгэсэн гүйцэтгэгчид бүрэн санхүүжүүлэх, тендерт өссөн үнийн санал эцсийнх байдаг боловч захиалагч дахин төсөв хийлгэн магадалшгүй зардал гэх мэт зэргээр санхүүжүүлдэггүй үлдээдэг.	Уг асуудлыг салбарын бие даасан хуулиар зохицуулдаг тул саналыг тусгах боломжгүй байна.
182		"Монголын авто замчдын холбоо" ТББ		2.Нэгж үнээр санал өгч шалгарсан тендерт оролцогчийн үнийн саналыг захиалагч дахин төсөв хийлгэдгийг болиулах	Ярилцах
183		"Монголын авто замчдын холбоо" ТББ		3.Шалгаруулалтыг зөвхөн нэгж үнээр үнэлэх	Ярилцах
184		"Монголын авто замчдын холбоо" ТББ		4.Гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг банкнууд хүү тооцдогийг болиулах	Баталгаа гаргахтай холбоотой асуудлыг Банкны тухай хуулиар зохицуулах тул саналыг тусгай боломжгүй байна.
185		"Монголын авто замчдын холбоо" ТББ		5.Үнэлгээний хороо шаардлагагүй материал шаарддагийг хуулиар хориглох,	Хуулиар гэрээг хэрэгжүүлэхэд ач холбогдолгүй шаардлагыг оролцогчдод тавихгүй байхыг тусгайлан заасан тул саналыг тусгах шаардлагагүй байна.
186		"Монголын авто замчдын холбоо" ТББ		6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.5-д "Хууль тогтоомжоор олгосон эрхийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх улсын чанартай авто замын засвар, арчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж заалтыг хэвээр буюу "Хууль тогтоомжоор олгосон эрхийн дагуу гүйцэтгэх улсын чанартай авто замын засвар, арчилгаатай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж тусгах.	Хуулийн төсөлд захиалагч өөрийн хараат үйл ажиллагаа явуулдаг этгээдэд бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх үүргийг даалгахаар тусгасан тул саналыг тусгах шаардлагагүй.
187		"Монголын авто замчдын холбоо" ТББ		7.Хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан худалдан авах ажиллагаанд мөрдөх гэрээний стандарт нөхцөлийг батлахдаа авто зам дэд бүтэц, барилгын салбарын ажил болон зөвлөх үйлчилгээнд Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо буюу ФИДИК-ээс боловсруулан гаргасан жишиг гэрээний баримт бичгийг өөрийн орны онцлогийг тусган оруулах	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батлах гэрээний загвар, нөхцөлийг батлахад гадаад улсын болон олон улсын байгууллагын сайн туршлагыг харгалзан үзэх боломжтой тул хуульд заах шаардлагагүй.

188	10	"Дэлхийн мишээл" ТББ	2021.11.11, 11/03	2. Хуулийн төслийн 7.3. Захиалагч 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажил, 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно. Гэвч энэ ажлыг дотоодын шаардлага хангасан аж ахуй нэгжүүд гүйцэтгэж болохгүй гэсэн үг биш.	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
189		"Дэлхийн мишээл" ТББ		3. Хуулийн төслийн 10.3. Үндсэн хуулийн 8-р зүйлийн дагуу 1.Монгол хэл төрийн албан ёсны хэл мөн. 2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл урлаг шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө гэж заасан байдаг тул тендерийн хэл Монгол хэл байх ёстой ба гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр бэлтгэж болно. /Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол түүний аюулгүй байдлыг хангах суурин дээрээс төрийн бүх бодлого бодогддог тогтолцоог бий болгоход төрийн албан ёсны хэл чухал юм/	Монгол хэлний тухай хуулиар зохицуулдаг тул давхардуулан зохицуулах боломжгүй.
190		"Дэлхийн мишээл" ТББ		4. Хуулийн төслийн 50 дугаар зүйл. Санал 50-3. Мэдээллийн санд бүртгэлтэй эрх хязгаарлаагүй 5-аас доошгүй сондгой тооны худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байх ба хувийн хэвшлийн төлөөлөл, эсхүл төрийн бус байгууллага, иргэний 2-оос доошгүй төлөөллийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцуулна. /Хөндлөнгийн төлөөлөл оролцох тусам татвар төлөгчийн мөнгийг хэрхэн зөв зарцуулж, хяналт тавих иргэдийн оролцоог бий болгох, мөн төлөөллийн ардчилал хэрэгжиж буйн баталгаа болдог тул дээрх төлөөллөөс заавал оролцуулах./ Энэ хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тогтолцоо ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангасан, шийдвэр гаргах ажиллагаанд хариуцлагатай, үр ашигтай, олон нийтийн итгэлийг хангасан байх нөхцөлийг бүрдүүлнэ/	Үнэлгээий хорооны ажлын цар хүрээнээс хамаарч гишүүдийн тоог 3 ба түүнээс дээш байхаар заасан ба гишүүдийн тоо олон болох тусам түүний 1/3-тэй тэнцэх тооны олон тооны хөндлөнгийн гишүүн оролцох нь зүйтэй юм. Иймд 2-оос доошгүй төлөөлөл оруулах саналыг хүлээн авах боломжгүй.

191		"Дэлхийн мишээл" ТББ		5. Хуулийн 50.5. Санал 50.5. Хувийн хэвшил болон төрийн бус байгууллага, тухайн орон нутаг, баг, хорооны иргэдийн төлөөлөл, бусад гишүүдийн орох эрхийг хязгаарлаж байгаа тул тухайн салбарт АЗ сертификаттай иргэд, мэргэжлийн холбоод, ТББ-ын төлөөллийг заавал оролцуулж орон нутгийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудыг хянах.	Саналын дагуу өөрчлөлт оруулж, салбарын холбоо, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оруулахаар тусгасан.
192		"Дэлхийн мишээл" ТББ		6.Хуулийн төслийн 50.12. Үнэлгээний хор оог тендер нээсэн даруйд байгуулахаар хуулийн төсөлд тусгасан нь захиалагчдад ашиг сонирхолтой байх, тендерт оролцогчдыг хязгаарласан байх тул тендерийн үнэлгээний хороог тендерийн нээлтээс өмнө байгуулсан байх ёстой.	Саналыг хүлээн авсан.
193		"Дэлхийн мишээл" ТББ		7. Хуулийн төслийн 53 дугаар зүйл. Төрийн худалдан авах ажиллагааны газар энэ хуулийн 52.5-д зааснаар мэргэшсэн ажилтны зөрчлийн мэдээллийг хүлээн авсан бол мэргэшсэн ажилтны эрхийг 1 жилийн хугацаанд түдгэлзүүлэх эрхгүй гэж оруулах саналтай байна.	Саналын дагуу худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтныг бүртгэлээс хасах шийдвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өөрчлөлт оруулахаар холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
194	11	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ	2021.12.07, 056	НЭГ.Шинэчилсэн найруулгын төсөлд шинээр оруулах заалт: 1. "7.5.3. Энэ хуулийн 7.3-т зааснаас дээш төсөв өртөгтэй ажил, үйлчилгээнд нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос тухайн шаардлагатай түүхий эд, бараа, материалыг ашиглан үйлдвэрлэсэн"	Ажил гүйцэтгэхэд ашиглах дотоодын бараанд хуулийн төслийн 7.4-т заасны дагуу давуу тооцох давхардуулах шаардлагагүй.
195		"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		2. "9.8. Захиалагч энэ хуулийн 9.4-д импортын бараа, ажил үйлчилгээг оролцуулахыг хориглоно"	Саналыг дагуу өөрчлөлтийг оруулсан.
196		"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		3. "16.2.7. Дээж өгөх боломжгүй ажил үйлчилгээнд тухайн салбарын чиг үүргийн мэргэжлийн холбооноос тухайн салбар чиглэлээр тасралтгүй ажиллаж байгаа тодорхойлолт гаргуулж хавсаргах"	Хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу оролцогчийн ирүүлэх баримт бичгийн тоо хэмжээг бууруулах ба шаардлагатай мэдээллийг төрийн холбогдох байгууллагын мэдээллийн сангаас шууд татаж авах зохицуулсан. Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд нийцэхгүй, оролцогчдод хүндрэл учруулах шалгуур нэмэхгүй.
197		"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		4. "18.4. Захиалагч тал 18.3-т заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд түүнийг тендерт оролцогчдод мэдэгдэх"	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.

198	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		5. "35.21. Захиалагч цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараанаас бусад барааг ерөнхий гэрээгээр авахыг хориглоно"	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
199	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		6. "61.7. Захиалагч оролцогч талтай гэрээ хийсний дараа техникийн тодорхойлолтод заасны дагуу бараа нийлүүлээгүй бол шүүхэд гомдол гаргах эрхтэй. Тухайн гомдол үндэслэлтэй бол хариуцлага тооцох, хар жагсаалтад оруулах эрхтэй.	Хуулиар зохицуулсан харилцаа тул давхардуулан заах шаардлагагүй.
200	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		7. "62.3. Захиалагч, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг хариуцлагыг нарийвчлан тусгаж оруулах /Энэ хуульд заасан дотоодын барааг тусад нь багцална гэсэн зүйл заалт хэрэгждэггүй, энэ хууль болон ТШӨХ-д заагаагүй шаардлага, зүйл заалт тавьдаг, захиалагч болон үнэлгээний хорооны буруугаас болж тендер удаа дараа зарлагддаг учраас хариуцлагыг тусад нь оруулах хэрэгтэй. /	Хариуцлага хүлээлгэх асуудлыг бие даасан хуулиар зохицуулах ба хуулийн төсөлд холбогдох өөрчлөлтийг тусгасан.
201	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		ХОЁР. Шинэчилсэн найруулгын төслийн заалтад оруулах нэмэлт: 1. Төслийн 1.1-д "боломжийг хангасан" гэсний дараа "дотоодын болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн" гэж нэмэх,	Өрсөлдөх тэгш боломжийг хангах хүрээнд дээрх асуудлыг тусгайлан хуулийн төслийн зорилтод тусгах боломжгүй.
202	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		2. Төслийн 5.1.2-д "Монгол Улсын хуулийн дагуу татварын эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн" гэсний дараа "хуулиар тогтоосон" гэж нэмэх,	Саналыг хүлээн авсан.
203	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		3. Төслийн 18.3-д "Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас" гэсний дараа "ажлын 5 хоногийн" гэж нэмэх,	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
204	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		ГУРАВ. Шинэчилсэн найруулгын төслийн заалтад оруулах өөрчлөлт: 1. Төслийн 7.3-д "300 сая" гэснийг "5,0 тэрбум",	Саналын дагуу барааны босго үнийг нэмэгдүүлж 1 тэрбум болгосон.
205	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		2. Төслийн 9.5-д "багцалж болно" гэснийг "багцлах ёстой",	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
206	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		3. Төслийн 10.1-д заасан жишиг баримт нь шаардлагагүй бичиг баримт ихтэй, олон янзын тодорхойлолт нэхдэг, цаг хугацаа болон явдал ихтэй байдаг. Иймд энэ жишиг баримтыг хялбар төвөггүй болгож нарийвчлан томъёолох,	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
207	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		4. Төслийн 10.5.4-ийн заалт нь тодорхой бус байгаа тул нэмж тодруулах,	Салбарын онцлогт тухайн зөвхөн тухайн салбарт ашиглагддаг шалгуур үзүүлэлтийг тодорхой нөхцөлд ашиглах боломжийг олгоно.

208	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		5. Төслийн 11.1 дэх заалт нь зарим тохиолдолд захиалагч талын шаардсан техникийн тодорхойлолт амьдралд нийцэхгүй шаардлага шалгуур тавьсан байдаг. Өөрөөр хэлбэл мэргэжлийн мэдлэг дутмаг байдалтай холбоотойгоор гарсан байдаг тул салбар салбарын мэргэжлийн холбоодоор баталгаажуулсан техникийн үзүүлэлтийг тусгасан жагсаалт гаргаж баталгаажуулах талаар тусгах,	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
209	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		6. Төслийн 11.6-д заасан “дээд доод” гэснийг тодруулах шаардлагатай байна. Учир нь дээд доод гэсний аль нэг үзүүлэлтийг тусгахгүй бол нэг бараан дээр техникийн тодорхойлолтыг холиод үзүүлэлтүүдээ бичих, оролцогч тал яг ямар бараа авахыг хүсч байгааг мэддэггүй, богино хугацаатай тендерийг хожуу мэдэх, захиалагчаас тодруулах хугацаагүй байдаг зэрэг хүндрэлүүд учирдаг.	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
210	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		7. Төслийн 13.1-д “Тендер шалгаруулалтын нийт төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол тендерийн баталгаа ирүүлэхийг шаардана” гэсний дараа “100 сая төгрөгөөс бага бол тендерийн баталгаа шаардахыг хориглоно” гэж нэмэх,	Хуулийн төсөлд тодорхой заасан тул нэмж зохицуулах шаардлагагүй.
211	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		8. Төслийн 21.2-д “45-аас” гэснийг “30-аас” гэж өөрчлөх,	Тендер шалгаруулалтад явцад захиалагчийн шийдвэр гаргах хугацааг сунгасан холбогдуулан оролцогчийн тендер хүчинтэй байх хугацаа дуусах эрсдэлтэй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
212	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		9. Төслийн 24.1-д “ 15 өдрийн” гэснийг “10 өдрийн ” гэж өөрчлөх,	Тендер шалгаруулалтын цар хүрээтэй холбоотойгоор хэт багаар тогтоох тендер шалгаруулалт амжилтгүй болох эрсдэлтэй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
213	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		10. Төслийн 48.1-д “ Худалдан авах ажиллагааг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна” гэж нэмж тусгах,	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулахаар хуулийн төсөлд тусгасан.
214	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		11. Төслийн 50.3-д “ Үнэлгээний хорооны нийт гишүүдийн 50-иас доошгүй хувийг мэргэжлийн холбоодоос оруулна” гэж нэмж тусгах,	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
215	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		12. Төслийн 59.3-д “Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим” гэснийг “ Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод” гэж өөрчлөх,	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.

216	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		13. Төслийн 60.9-д “3 гишүүний” гэсний ард хаалтанд “ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага-1, Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага-1, ТББ, Мэргэжлийн холбоо-1” гэж нэмэх,	Бүрэлдэхүүнийг томилох журмыг Засгийн газраас тогтоохоор заасан тул хуульд тусгайлан заах шаардлагагүй.
217	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		14. Төслийн 62.1-д “Төрийн албаны тухай хуулийн 48.1, хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 123.2-д тус тус зааснаар хариуцлага хүлээлгэнэ. <i>Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн зохих заалтыг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48.1, хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 123.2-д заасныг сахилгын шийтгэлийн аль тохирохыг ногдуулна” гэж нэмэх,</i>	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
218	"Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо" ТББ		ДӨРӨВ. Шинэчилсэн найруулгын төсөлд заавал оруулах ёстой заалт. МУ-ын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөрийн 1.2.16-д “Иргэд, хувийн хэвшил, бизнес эрхлэгчдэд олгож буй зээлийн хүүг нэг оронтой тоонд барих, баялаг бүтээгчдэд дарамтгүй, хүртээмжтэй санхүү, мөнгөний бодлогыг дэмжиж ажиллана”, 1.2.17-д “ Үндэсний үйлдвэрлэл, баялаг бүтээгчдээ дэмжих “Эх оронч худалдан авалт” хөтөлбөр санаачилна” гэж туссаны дагуу 2022 оныг “ Эх оронч худалдан авалтыг дэмжих”, төрийн худалдан авалтыг үндэсний үйлдвэрлэгчээс худалдан авах жил болгох, Засгийн газраас 2022 оны төсвийн худалдан авалтыг 2021 оныхоос 2 дахин нэмэгдүүлнэ гэж төлөвлөснийг манай холбоо бүрэн дүүрэн дэмжиж байгаа юм. Мөн Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн 3.3.13-д “Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ” гэж томъёолсон байдаг. Иймд Баялаг бүтээгч, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжлэг үзүүлж, импортлогч орноос эх орондоо бүтээгч, цаашлаад экспортлогч орон болохын тулд дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10-р зүйлийн 10.2-д “..... Энэ хуулийн 10.1.1-д заасан этгээд нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай	Хуулийн төсөлд дотоодын барааг цахим дэлгүүрт байршуулах, Засгийн газраас жагсаалт гаргаж уг жагсаалтад багтсан барааг зөвхөн дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авахаар тусгасан.

219	12	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ	2021.11.23, 126/2021	<p>1. САНАЛ: Шинэчилсэн төслийн 15.4. "Захиалагч санхүүгийн тайлан ирүүлэх хугацааг тендер шалгаруулалтын баримт бичигт заана." гэж заасныг "Захиалагч ямар хугацааны санхүүгийн тайлан ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана" гэж өөрчлөн оруулах саналтай байна. Үндэслэл: Утга зүй, найруулгын хувьд илүү оновчтой болгох</p>	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
220		"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		<p>2. САНАЛ: Шинэчилсэн найруулгын 14.5. "Гэрээг тусгай зөвшөөрөл эсхүл зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэх шаардлагатай бол захиалагч энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана." Гэсэн заалтыг "Гэрээг тусгай зөвшөөрөл эсхүл үйлдвэрлэгчийн итгэмжлэлтэй, албан ёсны борлуулагчийн эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх шаардлагатай бол захиалагч энэ тухай тендер шалгаруулалтын баримт бичигт заана" гэж оруулах саналтай байна. Үндэслэл: Одоо үйлчилж байгаа хуулийн хасагдсан 16.1.7 дэх заалт болох Үйлдвэрлэгчийн итгэмжлэлийг шинэчилсэн найруулгад нэмснээр баталгаатай чанартай бараа, бүтээгдэхүүн худалдан авах боломж бүрдэх ба гарал үүсэл нь тодорхойгүй, чанарын шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүн нийлүүлэгдэхээс сэргийлж, худалдан авсан бараа бүтээгдэхүүний засвар үйлчилгээ, программын шинэчлэл хийж чадахгүйгээс үүдэн ашиглаж чадахгүй байх болон үйлдвэрлэгч, гэрээт борлуулагчийн зөвшөөрөлгүйгээр ашигласнаас үүсэх бусад эрсдэлээс хамгаална.</p>	Хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу оролцогчийн ирүүлэх баримт бичгийн тоо хэмжээг бууруулах ба шаардлагатай мэдээллийг төрийн холбогдох байгууллагын мэдээллийн сангаас шууд татаж авах зохицуулсан. Тусгайлан үйлдвэрлэгчийн итгэмжлэл шаардлагатай салбарт захиалагч энэ тухай шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт шаардах заах эрхтэй байна. Үйлдвэрлэгчтэй байгуулсан хэлцлийг зөвхөн итгэмжлэлээр нотлох учир дутагдалтай байна.

221	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		<p>3. САНАЛ: Хуулийн шинэчилсэн найруулгын "5.1.2. Монгол Улсын хуулийн дагуу татварын эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй, эсхүл өр төлбөр төлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа" гэсэн заалтын "хугацаа хэтэрсэн өр" гэсэн ойлголтыг тодорхой болгож даатгал болон татварын өртэй эсэх хугацааг өмнөх сараар тооцох, эсвэл тухайн өр хэзээ үүссэнийг тогтоож, өмнөх нийгмийн даатгал болон татвараар үүссэн өрөө цаг тухайд нь төлж байсан эсэхийг үндэслэн шаардлага хангасан тендерт оролцогч эсэхийг тогтоох саналтай байна. Үндэслэл: Тендер шалгаруулалтад оролцогч байгууллагуудад нийгмийн даатгалын шимтгэл болон татварын тайлан өгсөн хугацаанаас хамаарч тендер нээлтийн өдөр өр үүсэх тохиолдлууд их гардаг. Үүнээс шалтгаалан тухайн өдрийн өглөөний 9 цагт системээр татварын өрөө шалгахад өргүй байсан компани 10 цагт тендер нээхэд өртэй гэж гарснаар тендерт унах тохиолдол байна. Иймд нийгмийн даатгал болон татварын өртэй эсэх хугацааг өмнөх сараар тооцох, эсвэл тухайн өр хэзээ үүссэнийг тогтоож, өмнөх нийгмийн даатгал болон татвараар үүссэн өрөө цаг тухайд нь төлж байсан эсэхийг үндэслэн шаардлага хангасан тендерт оролцогч эсэхийг тогтоох</p>	<p>Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 5.1.2-т хугацаа хэтэрсэн өртэй эсэхийг оролцогчийн ерөнхий нөхцөлийг шалгахад харгалзан үзэхээр тусгасан. Түүнчлэн шалгарсан тохиолдолд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хэмжээний өрийг нөхөн төлөх боломжийг олгохоор хуулийн төслийн тендер хянан үзэх хэсэгт заасан.</p>
222	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		<p>4. САНАЛ: Шинэчилсэн хуулийн төслийн 38-р зүйлд "Эд хөрөнгө, тоног төхөөрөмж, суурь машин, машин механизмын эд анги, дагалдах хэрэгсэл, сэлбэг нь орлуулах боломжгүй буюу өөр дагалдах хэрэгсэл, программ ашигласнаас үүдэн үндсэн тоног төхөөрөмж эвдрэх зогсох эрсдэлтэй бол үйлдвэрлэгч болон гэрээт борлуулагчаас шууд худалдан авалт хийнэ" гэсэн заалт оруулах саналтай байна. Үндэслэл: Тоног төхөөрөмж, машин механизмын засвар үйлчилгээнд шаардагдах сэлбэг, дагалдах хэрэгсэл нь тухайн тоног төхөөрөмжийн онцлогоос хамаарч хийцлэл, ажиллагаа, элэгдэх хугацаа, чанар стандартын хувьд дахин давтагдашгүй байдаг бөгөөд тохирохгүй сэлбэг, дагалдах хэрэгсэл ашигласнаас үүдэн үндсэн тоног төхөөрөмжийн бусад эд анги эвдрэх, ажиллагаа хэвийн бус болох, ашиглалтаас гарах хүртэл эрсдэл гарж болдог тул дээрх саналыг шинэ хуулийн төсөлд оруулж өгнө үү.</p>	<p>Тухайн барааг орлуулашгүй тохиолдолд нэг эх үүсвэрээс худалдан авах боломжийг хуульд заасан.</p>

223	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		5. САНАЛ: Хуулийн шинэчилсэн найруулгын "9.2. Захиалагч нийт төсөвт өртөг нь 20 сая төгрөгөөс бага бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авч болно." гэсэн заалтын босго үнийг салбар аж ахуй нэгжийн онцлогоос шалтгаалан шатлалтай тогтоох саналтай байна.	Салбарт ялгамжтай тогтоох нь шууд худалдан авах босгыг өсгөх эрсдэлтэй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
224	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		6. САНАЛ: Шинэ хуулийн төслийн 11.3-т "Захиалагч оролцогчийн санал болгох барааг үйлдвэрлэх, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгаж болно" гэснийг "Захиалагч оролцогчийн санал болгох барааг үйлдвэрлэх, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх хугацаа болон баримтлах шаардлагыг баталгаатай эх сурвалжаас тодруулга аван, үнэн бодитойгоор техникийн тодорхойлолтод тусгана" гэж шинэ төсөлд оруулах саналтай байна. Үндэслэл: Захиалагч судалгаагүйгээр тендер зарласнаар бараа материалын төсөвт өртөг хэт өндөр эсхүл хэт бага байх, нийлүүлэх хугацаа хэт богино эсвэл хэт урт байх нөхцөлүүд үүсдэг бөгөөд эдгээр шалтгаанаас үүдэн чанарын шаардлагад нийцсэн ч тендерт шалгарахгүй байх, тендер олон дахин зарлагдсан ч "хамгийн сайн үнэлэгдсэн" тендер гарч ирэхгүй байх нөхцөл үүсдэг.	Саналын дагуу холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.
225	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		Мөн дээр хэлэлцсэн 6 саналуудаас гадна доорх санал хүсэлтүүд аж ахуй нэгжүүдээс ирсэн байна. 1. Хуулийн төслийн нэрийг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хууль гэхийг "Төрийн болон орон нутгийн төсвөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хэмээн өөрчлөх. Учир нь, МУ-ын Төсвийн тухай 2011 оны хуулийн заалтууд болон уг хуулийн төслийн үндсэн утга агуулгад "улсын төсөв" хэмээх утга агуулга, нэршил л яригдах тул хуучин хуулийн нэршил үл тохирохоор харагдаж байна. Мөн үүнтэй уялдуулан шинэчилсэн найруулгын зүйл, заалтууд дах "... өмчийн хөрөнгө" гэх ойлголтыг төсөв хэмээн өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна.	Уг хуулийн төсөл нь улсын болон орон нутгийн төсөв, зээл тусламжийн хөрөнгө, захиалагч байгууллагын өөрийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн эх үүсвэрээр худалдан авах ажиллагаанд хамаарч байгаа тул саналын дагуу өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

226	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		2. Одоо үйлчилж байгаа хуулийн хасагдсан 14.1.4. дэх заалтыг шинэчилсэн найруулгын 5 дугаар зүйл. Ерөнхий шаардлага-ын 5.1 дэх заалтад оруулах. Учир нь "... гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй..." түүнтэй холбогдуулан шүүхийн шат шатны шийдвэр, тогтоолд авагдаж байсан нь тухайн сонирхогч этгээдийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг тодорхойлоход тавигдах зүй ёсны ерөнхий шаардлагуудын нэг гэж үзэж байна.	Хуулийн төсөлд худалдан авах гэрээний үүргээ гүйцэтгэхэд мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх эсхүл эрх бүхий бусад этгээд тогтоосон бол ерөнхий шаардлага хангахгүй этгээдийн жагсаалтад бүртгэхээр заасан. Уг жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусаагүй бол ерөнхий шаардлага хангаагүй гэж үзэх зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байна.
227	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		3. Шинэчилсэн төслийн 22-р зүйл. 22.3 дах хэсэгт "... 10.821.10-д..." болон "... 22.222.2-т..." гэх илт алдаатай иш татсан хуулийн заалтыг хянан үзэж, зөв заалтаар нь засварлах.	Саналын дагуу техник алдааг залруулав.
228	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		4. Шинэчилсэн төслийн 22-р зүйл. 22.4 дэх хэсэгт "... 7.37.3-т..." гэх илт алдаатай иш татсан хуулийн заалтыг хянан үзэж, зөв заалтаар нь засварлах.	Саналын дагуу техник алдааг залруулав.
229	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		5. Шинэчилсэн төслийн 22-р зүйл. 22.6 дэх хэсэгт "... 22.522.5-д..." гэх илт алдаатай иш татсан хуулийн заалтыг хянан үзэж, зөв заалтаар нь засварлах.	Саналын дагуу техник алдааг залруулав.
230	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		6. Шинэчилсэн төслийн 25-р зүйл. 25.4 дэх хэсэгт "... 28.3.1-д..." гэх алдаатай иш татсан хуулийн заалтыг хянан үзэж, зөв заалтаар нь засварлах. Учир нь тухайн заалт уг шинэчилсэн хуулийн төсөлд огт байхгүй заалт юм.	Саналын дагуу техник алдааг залруулав.
231	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		7. Шинэчилсэн төслийн 27-р зүйл. 27.3.1 дэх заалтад "... 14-161416 дугаар зүйл..." гэх илт алдаатай иш татсан хуулийн заалтыг хянан үзэж, зөв заалтаар нь засварлах. Учир нь тухайн заалт уг шинэчилсэн хуулийн төсөлд огт байхгүй заалт юм.	Саналын дагуу техник алдааг залруулав.
232	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		8. Шинэчилсэн төслийн 30-р зүйл. 30.5 дах хэсэгт заахдаа иш татсан "...31.3-т..." гэх хуулийн ишлэл нь тухайн 30.5. дах заалтын утга агуулгатай нийцэлгүй байх тул уг заалтыг хянан үзэж, зөв заалтаар нь засварлах.	Саналын дагуу техник алдааг залруулав.

233	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ	9. Шинэчилсэн найруулгын 46-р зүйл 46.5 "Захиалагчийн өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ байнгын шаардлагатай бол гэрээний үргэлжлэх хугацаа 2-4 жил хүртэл хугацаагаар байж болно" болон 46.6 "Захиалагч өөрийн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд шаардагдах нийтлэг үйлчилгээний гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг 3 хүртэл жилээр байгуулж болно" заалтууд нь хуулийн төслийн 5-р зүйлд заасан өрсөлдөх тэгш боломжийг хангах зарчмыг алдагдуулахыг анхаарах, гэрээний хугацаанд буюу дараа, дараагийн төсвийн жилд тендер зохион байгуулагдахгүй гэж ойлгогдож байгаа тул эдгээр заалтыг засварлах саналтай байна.	Холбогдох хэсэгт байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээний гэрээг нэгж үнээр байгуулахаар өөрчлөлт оруулсан.
234	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ	10. Шинэчилсэн төслийн 52-р зүйл. 52.2 дахь хэсэгт "... энэ хуулийн -д заасан зарчмыг баримтална." гэж бичигдсэн байх боловч одоо хэрэгжиж буй хуульд байх зарчимтай холбоотой ганц ч заалт шинэчилсэн найруулгын төсөлд байхгүй, ямар зарчимд үндэслэн албан тушаалтан, ажилтан нь худалдан авах ажиллагаа дах шийдвэрээ гаргах нь тодорхойгүй байна.	Саналын дагуу техник алдааг залруулав.
235	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ	11. Шинэчилсэн төслийн 60-р зүйл. 60.3 дахь хэсэгт "... 60.1660.16-т" гэх алдаатай иш татсан хуулийн заалтыг хянан үзэж, зөв заалтаар нь засварлах саналтай байна.	Саналын дагуу техник алдааг залруулав.
236	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ	12. Тоног төхөөрөмж, түүний сэлбэг материал худалдан авах тендерт оролцогчид нь Монгол дахь оюуны өмчийн газраас албан ёсны дистрибьютер мөн эсэх, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн эсэх талаар тодруулга авах.	Оюуны өмчийн эрхтэй эсэхийг гэрчлэх асуудлыг тусгай бие даасан хэд хэдэн хуулиар зохицуулж байгаа тул үүнийг хуулийн төсөлд давхардуулан тусгах боломжгүй байна.
237	"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ	13. Тоног төхөөрөмж, түүний сэлбэг материал худалдан авах тендерт оролцогчид нь Монгол дахь оюуны өмчийн газраас нийлүүлэх гэж буй бараа бүтээгдэхүүнүүд дээрээ патент, барааны тэмдэгт, зохиогчийн эрхийг зөрчөөгүй нь үнэн гэсэн тодорхойлолт авах.	Нэмэлт материал шаардах үндэслэл тул хүлээн авах боломжгүй.

238		"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		14. МҮХАҮТ-аас шалгаруулсан TOP100 аж ахуй нэгжүүд тендерийн бичиг баримтын бүрдүүлэлт, лавлагаа, тодорхойлолтууд, нотариат, орчуулга, нотлох баримтуудыг багасгах.	Хуулийн төсөлд тендерт оролцогчоос шаардах баримт бичгийн тоог бууруулсан, хуульд тусгайлан зааснаас бусад баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэхийг шаардахгүй байхаар заасан тул саналын дагуу тусгайлан ийм зохицуулалтыг тусгах шаардлагагүй.
239		"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		15. Хуулийн төслийн 5.1.2-т заасан НДШ болон Татварт хугацаа хэтэрсэн өртэй... бол ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ гэсэн заалт дээр: "100,000₮ дээш өртэй бол шаардлага хангаагүй" гэж үзнэ гэсэн саналтай байна	Санал авахаар хүргүүлсэн хуулийн төслийн 5.1.2-т хугацаа хэтэрсэн өртэй эсэхийг оролцогчийн ерөнхий нөхцөлийг шалгахад харгалзан үзэхээр тусгасан. Саналын дагуу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд учрах дарамтын багасгах зорилгоор шалгарсан тохиолдолд татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хэмжээний өрийг нөхөн төлөх боломжийг олгохоор хуулийн төслийн тендер хянан үзэх хэсэгт заасан.
240		"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		16. Шинэчилсэн найруулгын 15.3, 16.3 заалтад байх аль шаардлагатайг тендерийн баримт бичигт заана гэснийг задалж ямар нөхцөлд шаардахыг тодорхой болгох саналтай байна.	Тухайн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний онцлогт нийцүүлэн үнэлгээний хороо уг шаардлагыг тодорхойлох тул саналын дагуу өөрчлөлтийг тусгах боломжгүй байна.
241		"Метал боловсруулалт, инженерчлэлийн холбоо" ТББ		17. "27.3.1. энэ хуулийн 14-161416 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлага хангасан байх," гэснийг өөрчлөх	Саналын дагуу техник алдааг залруулав.
242	13	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ	2021.12.02, 82	1.Хуулийн төслийн 35 дугаар зүйлд яаралтай хэрэгцээтэй байдал, түүнийг захиалагч урьдчилан мэдэх боломжгүй байсан, энэ захиалагчийн үйл ажиллагаа удааширнаас шалтгаалаагүй зэрэг нөхцөл байдлыг хэрхэн тодорхойлох, хэн хяналт тавихыг нарийвчлан тодорхойлоогүй байна. Энэ нь төрийн байгууллага яаралтай хэрэгцээтэй байдал, яаралтай нөхцөл байдал нэрийн дор нээлттэй тендергүйгээр худалдан авалт хийх нөхцөлийг үүсгэж байгаа юм. Тиймээс уг хуулийн төсөлд яаралтай хэрэгцээтэй байдал, яаралтай нөхцөл байдлыг нарийвчлан тодорхойлж хуулийн төслийн 35.4-т заасан "хэлэлцээний тэмдэглэл"-ийг ил тод болгох зохицуулалт нэмж тусгах нь зүйтэй.	Саналын дагуу өөрчлөлт оруулсан.

243	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ		2.Худалдан авах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, энэ чиглэлээр олон нийтийн хяналт бий болгох үүднээс худалдан авах ажиллагаанд оролцогчийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг авах, эсхүл улс төрд нөлөө бүхий этгээд, тэдгээрийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой эсэх тухай мэдээллийг авах, ил тод болгох зохицуулалт тусгах.	Уг асуудлыг тусгайлсан хуулиар зохицуулдаг бол давхардуулан тусгах боломжгүй. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн төслийг дагалдан батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар хуулийн этгээдийн "эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн нэр" нээлттэй мэдээлэлд хамаарах тухай өөрчлөлт орсон тул аж ахуйн нэгж тендер шалгаруулалтад оролцож байгаа эсэхээс үл хамааран уг мэдээлэл нийтэд ил тод болох юм. Уг хууль Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр мөрдөгдсөнөөр хүчинтэй үйлчилж эхлэх болно.
244	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ		3.Хуулийн төсөлд худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн бүлэг шинээр нэмж, уг цахим системийн үйл ажиллагааг хуулиар баталгаажуулах нь зүйтэй. Тус бүлэгт дараах зохицуулалтыг тусгах болох юм. 3.1.Цахим системээр дамжуулан ил тод болгох мэдээллийн бүрдэл, задаргаа, системд байршуулах хугацааг нэг бүрчлэн тодорхойлох.	Уг хуулийн төсөл нь бүхэлдээ ил тод байдлыг хангах агуулгатай бөгөөд худалдан авах ажиллагааны бүх үе шатанд холбогдох мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим системээр ил тод, нээлттэй нийтлэхээр заасан тул "ил тод байдал" гэсэн бүлэг нэмэх нь ач холбогдолгүй байна.
245	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ		3.2.Цахим системд байршуулдаг одоогийн мэдээллээс гадна тендерийн код, худалдан авах гэрээ, гэрээний дүн, хэрэгжилтийн мэдээлэл, албан тушаал зэрэг мэдээллийг нэмж тусгах зохицуулалт оруулах.	Хуулийн төсөлд уг асуудал тусгагдсан.
246	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ		3.3.Мэдээллийн санг бүрдүүлэх, үнэн зөв байдлыг хангах талаарх холбогдох этгээдүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох.	Хуулийн төсөлд уг асуудал тусгагдсан.
247	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ		3.4.Нээлттэй мэдээллийн стандартыг хангах буюу машинаар унших боломжтой нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийг ил тод болгох шаардлагыг тусгах.	Саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан
248	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ		3.5.Цахим систем нь Шилэн данс болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сантай харилцан мэдээлэл солилцох шаардлагыг хуульчлах.	Хуулийн төсөлд цахим системээр дамжуулан шалгах боломжтой болон хууль тогтоомжийн дагуу төрийн эрх бүхий байгууллагаас нийтэд ил тод хөтөлдөг мэдээллийг тендер шалгаруулалтад харгалзан үзэхээр тодорхой зохицуулалтыг тусгасан.

249	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ	4.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компанийн худалдан авалтын ил тод байдал судалгааны тайланд Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем болон Шилэн дансны мэдээлэл асар их зөрүүтэй байгааг дурджээ.[1] Иймд мэдээллийн зөрүүг арилгах, төрийн худалдан авах ажиллагаанд ил тод байдлыг нэмэгдүүлэх үүднээс Шилэн дансны тухай хуульд дараах өөрчлөлтийг оруулах нь зүйтэй байна. Үүнд: 4.1.Шилэн дансны хуульд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн ангиллыг энэ хуульд нийцүүлэх замаар худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлын шаардлагыг бүх төрлийн төрийн өмчит компаниуд нэг мөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	Шилэн дансны тухай хуулиар зохицуулах асуудал тул саналыг холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.
250	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ	4.2.Шилэн дансны цахим хуудас нь Төрийн худалдан авах цахим системд орсон анхдагч өгөгдлийг Шилэн дансны цахим хуудаст татаж ашиглах боломж бүрдэж, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй алдаа, мэдээллийн зөрүү гарахаас сэргийлнэ.	Шилэн дансны тухай хуулиар зохицуулах асуудал тул саналыг холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.
251	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ	4.3.Шилэн дансанд ханган нийлүүлэгч компанийн регистрийн дугаарыг оруулдаг болох. Ингэснээр компанийн нэр, регистрын дугаарыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас татаж ашиглах боломж бүрдэж, хуулийн этгээдийн нэрийг санаатай болон санамсаргүйгээр олон өөр янзаар бичиж төөрөгдөл үүсгэж буй нөхцөл байдлыг арилгана.	Шилэн дансны тухай хуулиар зохицуулах асуудал тул саналыг холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.
252	"Нээлттэй нийгэм форум сан" ТББ	4.4.Нээлттэй мэдээллийн стандартыг хангах буюу машинаар унших боломжтой нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийг ил тод болгох шаардлагыг тусгах.	Саналын дагуу өөрчлөлт оруулсан.

253		"Нээлттэй нийгэм форум сан" ТББ	4.5.Орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог оновчтой болгож, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хэрхэн, ямар давтамжтай хяналт тавих, хяналтын мөрөөр авах арга хэмжээ, түүний хэрэгжилтийн нийтэд мэдээлэх зохицуулалт тусгах. Учир нь орон нутагт Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд шат шатны ИТХ хяналт тавих зохицуулалттай боловч хууль хэрэгжсэн хугацаанд дээр дурдсан судалгаанд хамрагдсан орон нутгийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын хувьд ИТХ-аас шилэн дансны үйл ажиллагаанд нь хяналт тавьсан тохиолдолд гараагүй байна. Тэрчлэн Таван Толгой ХК-аас бусад судалгаанд хамрагдсан орон нутгийн өмчит компаниуд шилэн данс хөтөлдөггүй байна.	Шилэн дансны тухай хуулиар зохицуулах асуудал тул саналыг холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.
254		"Нээлттэй нийгэм форум сан" ТББ	4.6.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд компанийн дотоод хяналтын нэгж хяналт тавих боломжийг хуульчлах. Ингэхдээ дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагаанд компанийн ТУЗ, төрийн хяналтын байгууллага давхар хяналт тавьдаг байх, тэдгээр хяналтын мэдээллийг нийтэд ил тод болгох тогтолцоог хуульчлах.	Шилэн дансны тухай хуулиар зохицуулах асуудал тул саналыг холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.
255		"Нээлттэй нийгэм форум сан" ТББ	4.7.Шилэн дансны тухай хуулийн хариуцлагын тогтолцоог илүү боловсронгуй болгох. Учир нь Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр зааснаас уг хуулийн үйлчлэлд хамаарахгүй төрийн өмчит болон орон нутгийн өмчит компани, тэдгээрийн албан тушаалтанд хариуцлага тооцох боломжгүйд хүрээд байна.	Шилэн дансны тухай хуулиар зохицуулах асуудал тул саналыг холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн.

256	14	"Энх гэрэлт хас" ТББ	2021.12.17, A21-21	<p>1.Санал: 7-3. 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцоно гэсэн нь дотоодын үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг хязгаарласан заалт гэж үзэж байна. Өнөөгийн нөхцөлд 300 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа үйлчилгээг нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжүүд дотооддоо хангалттай олон бий. Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоол "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд дотоодын үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжүүдээ дэмжих, ингэснээр дотоодын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сайжрах, улсад төвлөрүүлэх татвар хураамж нэмэгдэх, тухайн аж ахуйн нэгжид ажиллаж буй ажилчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх зэрэг сайн талууд харагдаж байна. Иймд бараа, үйлчилгээ худалдан авахад гадаадын этгээд оролцох босго үнийг 1 тэр бум болгох саналтай байна.</p>	<p>Саналыг хүлээн авч бараа нийлүүлэх тендер шалгаруулалт оролцох гадаадын этгээдийн оролцох босго үнийг 1.0 тэрбум болгосон. Харин үйлчилгээний салбарт гадаадын этгээд дотоодын этгээдтэй өрсөлдөж байгаа бодит тохиолдол цөөн тул босго үнийг 300.0 сая төгрөгөөс дээш нэмэгдүүлэх шаардлагагүй.</p>
257		"Энх гэрэлт хас" ТББ		<p>2. Санал:10.3 Үндсэн хуулийн 8-р зүйл: 1 .Монгол хэл төрийн албан ёсны хэл мөн. 2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хун амын оор хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл урлаг шинжлэх ухааны уйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө. Заасан байдаг тул тендерийн хэл Монгол хэл гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол олон улсын худалдаанд өрнөн хэрэглэгддэг хэл дээр бэлтгэж болно. /Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол түүний аюулгүй байдлыг хангах суурин дээрээс төрийн бух бодлого бодогддог тогтолцоог бий болгоход төрийн албаны ёсны хэл чухал юм/ иймээс Үндсэн хуулийн заалтыг үндэслэн тендерийн албан ёсны хэл монгол хэл гэж зааж өгөөд гадаадын этгээд оролцох бол монгол хэлээс гадна олон улсын худалдаанд өргөн хэрэглэдэг хэлээр бэлтгэж болно гэж оруулах саналтай байна.</p>	<p>Төрийн байгууллагын үйл ажиллагаа явуулах хэлийг бие даасан хуулиар зохицуулдаг тул давхардуулан заах шаардлагагүй.</p>

258	"Энх гэрэлт хас" ТББ		Санал 50-3. Мэдээллийн санд бүртгэлтэй эрх хязгаарлаагүй 5 -аас доошгүй сондгой тооны худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байх ба хувийн хэвшлийн төлөөлөл, эсхүл төрийн бус байгууллагын 2 доошгүй төлөөллийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцуулна. Хөндлөнгийн төлөөлөл оролцох тусам татвар төлөгчийн мөнгийг хэрхэн зөв зарцуулж буй тал дээр хяналт тавих иргэдийн оролцоог бий болгоно. Энэ хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тогтолцоо ил тод, өрсөлдөөн тэгш боломжийг хангасан, шийдвэр гаргах ажиллагаанд хариуцлагатай, ур ашигтай, олон нийтийн итгэлийг хангасан байх нөхцөлийг бүрдүүлнэ.	Үнэлгээийг хорооны ажлын цар хүрээнээс хамаарч гишүүдийн тоог 3 ба түүнээс дээш байхаар заасан ба гишүүдийн тоо олон болох тусам түүний 1/3-тэй тэнцэх тооны олон тооны хөндлөнгийн гишүүн оролцох нь зүйтэй юм. Иймд 2-оос доошгүй төлөөлөл оруулах саналыг хүлээн авах боломжгүй.
259	"Энх гэрэлт хас" ТББ		3. Санал 50-5. хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын бусад иргэд оролцох орох эрхийг хязгаарлаж байгаа тул тухайн салбарын болон төрийн бус байгууллага хувийн хэвшил орон нутгийн иргэдийн төлөөллийн эрх нь хязгаарлагдаагүй төлөөллөөс оролцуулна.	Саналын дагуу өөрчлөлт оруулж, салбарын холбоо, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оруулахаар тусгасан.
260	"Энх гэрэлт хас" ТББ		4. Санал:53-4 Төрийн худалдан авах ажиллагааны газар энэ хуулийн 52.5-д зааснаар мэргэшсэн ажилтны зөрчлийн мэдээллийг хүлээн авсан бол мэргэшсэн ажилтны эрхийг 1 жилийн хугацаанд түдгэлзүүлэх эрхгүй гэж оруулах саналтай байна. Үнэлгээнд оролцож явахад төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагууд өөрсдөдөө илт давуу байдал бий болгох, өөрсдийн талд шийдүүлэх гэдэг. Харин түүний эсрэг санал өгсөн гишүүнийг дараагийн тендер оролцох эрхийг хязгаардаг тул энэ заалтыг онцгойлон анхаарч үзнэ үү.	Саналын дагуу худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтныг бүртгэлээс хасах шийдвэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өөрчлөлт оруулахаар холбогдох хэсэгт өөрчлөлт оруулсан.